

**XVII ЗУУНЫ ЭХЭН ХАГАС ДАХЬ ХАЛХ-МИНГИЙН ТҮР ХУДАЛДАА<sup>1</sup>**

ДАРЬЖАВ

*Бээжингийн Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор, доктор*

**Товч агуулга:** 1934 онд Цахарын Лигдэн хаан нас барсны дараагаар Чин улс говийн өмнөх Монголын газар нутгийг өөрийн шууд хяналтдаа авчээ. Гэвч говийн умардын Халх Чин улсын хориг саадыг үл харгалзан, хэсэг хугацаанд Мин улстай уламжлалт худалдааны харилцаагаа сэргээж чаджээ. Мин улс нь Халхаас адуу худалдан авч дайнд ашиглах адууны хомсдлыг нөхөн хангаж түүнчлэн Халх аймгийг түшиглэн Чин улсын баруун тийш хэрэгжүүлж буй цэргийн ажиллагааг тогтоон хязгаарлахыг оролдож байв. Чин улс говийн умардын Халхыг цэргийн хүчээр сүрдүүлэх, худалдааны эрх амлах зэрэг арга хэрэглэн Мин улстай худалдааны харилцаагаа зогсоохыг тулган шаардав. Ингэснээр Халх Чин улстай элчийн шугамаар харилцаж худалдаа хийх нөхцөл рүү шилжсэн. Чин улс Түмэд, Харчин зэрэг хоёр аймгийн нэрээр Мин-Монголын худалдааны боомтуудыг хяналтдаа авснаар зөвхөн эдийн засгийн хэрэгцээ шаардлагаа хангаад зогсохгүй, улмаар Халхыг худалдааны талаар хянах болов. Мин улс нь умард хил хязгаараа Чин улсын цэргийн довтолгооноос хамгаалахын тулд Чин улсын шууд бус худалдааг чимээгүйхэн зөвшөөрчээ.

**Түлхүүр үг:** Халх; Мин улс; Чин улс; худалдаа

**Keywords:** Khalkha, Ming dynasty, Qing Empire, Trade

Хятадын номын сангийн ангилал: K249. Баримт бичгийн код: А. Өгүүллийн дугаар: 1002 - 8587 (2011) - 02 - 0080 - 10.

1634 онд Чин улсын (хожуу Алтан улс) цэргийн сүрдүүлэг дор Цахарын Лигдэн хаан цэрэг, иргэдээ дагуулан баруун зүг Хөх нуур луу нүүж яваад замдаа өвчний улмаас тэнгэрт халив. Үүний дараа говийн умард дахь Халх монголчууд хэсэг хугацаанд Мин улстай худалдааны харилцаагаа сэргээсэн нь говийн өмнөх монголчуудыг хяналтдаа авсан Чин гүрний бодлоготой зөрчилдөж байв. Мин улс Халхаас адуу идэвхтэй худалдан авсан нь Чин улсын цэргийн хүч хойд хилд

<sup>1</sup> Тус өгүүлэл нь 达力扎布, 17世纪上半哈喀尔喀与明朝的短暂贸易, “清史研究“, 2011年5月第2期, 80-89-д хэвлэгдсэн. Зохиогчийн зөвшөөрөлтэйгээр орчуулж хэвлэв.

халдахаас сэргийлэх зорилготой байжээ. Үүний улмаас Мин болон Чин улсын хоёр тал Халхын худалдааг тойрсон стратегийн өрсөлдөөн өрнүүлэв.

Энэ өгүүллээр түүхийн факт баримт, эх хувийг анхан шатны байдлаар судлан шинжлэхийг зорьсон юм.

## НЭГ

1571 онд Мин улс, Түмэдийн Алтан ханд “Шунь-и ван (顺义王 эв зүйг эрхэмлэгч ван)” хэмээх хэргэм цол олгосны дараагаар Монголтой найрамдлын хэлэлцээ хийж, харилцан худалдаа явуулах болжээ. Монголын баруун Харчин, Түмэд, Ордос зэрэг гурван аймаг тус тусдаа Мин улсын Сюаньфү (宣府), Датун (大同), Янсуй (延绥) зэрэг хил хязгаарын хотуудтай худалдаа хийж байв. Мин улсын Сизун хааны долдугаар онд (1627), Цахарын Лигдэн хаан цэргүүдээ дагуулан Шар мөрнийг гаталж урагш явж, Мин улсын Сюаньфү (Монгол нэр Баянтүмэн хот), Датун зэрэг хотын ойролцоо буудаллан, Монголын баруун гурван аймгийг эзлэн авсан байна. Лигдэн хаан, Мин улсын Сюаньфү, Датун, Шаньси (山西), Янсуй зэрэг хотуудаас Монгол гурван аймагт олгодог худалдааны эрх мөн Цахар, Өвөр халх таван аймагт урьд цагт Ляодуны бүс нутгаас авч байсан худалдааны эрхийг үргэлжлүүлэхийг шаардсан байна. 1629 онд Мин улс Цахарыг ашиглан Манжийн (хожуу Алтан улс) цэргийн хүчийг хязгаарлах зорилгоор арилжаа нээж бүх худалдааны эрхийг Лигдэн хаанд олгожээ. Энэхүү худалдааны орлого болон олгосон шагналын нийлбэр нь нийтдээ нэг сая гаруй лан мөнгөтэй дүйцэж байв. Улмаар Монголын бүх овог аймаг, отгууд Мин улстай худалдаа хийхэд Лигдэн хааны захиргаагаар явах боломжтой болов<sup>2</sup>.

Говийн хойд талын халхчууд (цаашид Халх) нь Мин улсын сүүлчийн үед Түмэд, Харчин зэрэг аймгуудаар дамжуулан Мин улстай тогтмол худалдаа хийсэн ба тэр ч байтугай Ойрадын мал сүргийг дамлан худалдаж байжээ<sup>3</sup>. Цахар аймаг баруун тийш хөдөлж Мин улсын Сюаньфү, Датун хойд зүг орчимд нүүдэлсний дараа умард зүг Халх руу довтлох цуу яриа тараасан нь тэдний хувьд маш их аюул занал болжээ<sup>4</sup>. Оросын архивын баримтаас үзэхэд 1635 онд Халхын засагт Омбо Эрдэнэ хунтайж (оросууд Алтан хан хэмээн нэрлэдэг) нь гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс Оросын элч төлөөлөгчтэй ёслолын тангараг өргөж Хаант Орос улсад үнэнч байхаа илэрхийлсэн. Энэхүү үйл явдал нь шаардлагатай үед Оросын талаас тусламж авах зорилготой алхам байв. Омбо Эрдэнэ хунтайж Оросын элчид хэлэхдээ: Халх болон Мин улсын хоорондын худалдаа бүр мөсөн

<sup>2</sup> 参见拙著《明代漠南蒙古历史研究》，内蒙古文化出版社，1997年，第303页。

<sup>3</sup> 明代漠南蒙古历史研究》，第248-249页。

<sup>4</sup> 苏联科学院远东研究所等编、厦门大学外文系翻译组译、黑龙江大学俄语系翻译组校：《十七世纪俄中关系》第一卷第一册，第34、35、36号文件，商务印书馆，1978年，第136-140页。

тасарсан ба Цахарын хаан дайн өдөөсний улмаас манай хүмүүс урт удаан хугацаанд Мин улс болон Тангудын зүгт очиж чадахгүй байна<sup>5</sup> гэжээ.

1632 онд Хунтайж (Тэнгэр цэцэний зургаадугаар он) үлэмжхэн цэрэг авч, Цахар нутагт цөмрөн орж ирсэнд Лигдэн хаан албат ардаа авч Шар мөрнийг гатлан баруун тийш хөдөлжээ. Харин Мин улс, Лигдэн хаантай харилцаа тасарсан гэж үзээд худалдааны эрх, шагналыг бүрмөсөн зогсоожээ<sup>6</sup>. Цахарчууд энэ мэдээг сонсоод худалдааны шагнал болон арилжааг буцааж сэргээхийг шаардаж Мин улсын хилийн хот болох Янсуй, Нинся (宁夏) зэрэг бүс нутагт хэд хэдэн удаа довтлов. Гэвч Мин улс энэ явдлыг үл анхаарч тэдний шаардлагад хариу өгөхөөс татгалзав<sup>7</sup>. 1934 онд (Тэнгэр цэцэний наймдугаар он) Лигдэн хаан Хөх нуур явах замдаа өвчнөөр нас барав. Иймээс Цахарын овог аймаг хожуу Алтан улсад дагаар оржээ. Түүнчлэн Түмэд болон Ордосын хоёр аймаг Халхаас салж хожуу Алтан улстай нэгдсэний дараа Хунтайж тэднийг хуучин нутагт нь буцаан суурьшуулах зарлиг буулгав. Бас Хөх хотын (归化城) Түмэд, Харчин аймгаас элч илгээж Мин улсын Шаху (杀虎 *Монгол нэр Шүргий боомт*), Жанчхүү (张家口) зэрэг боомтод очиж урьд өмнө олгож байсан худалдааны эрхийг шаардсан<sup>8</sup>. Мин улсын хаан Чунжэний (崇禎-七年, 1634) долоодугаар оны сүүлчээр Халхын элч Хөх хотын Түмэд аймагт ирснээр Мин улстай худалдааны харилцааг сэргээхийг хүссэн байна. Мин улс энэ саналыг хүлээн зөвшөөрч маш хурдан хариу өгчээ. Тэнгэр цэцэн хааны есдүгээр оны (1635 он, Мин улсын Чунжэний 崇禎 наймдугаар он) 1-р сард Мин улсын Сюаньдагийн (Сюаньфү, Датун) ерөнхий захирагч Ян Сычан (杨嗣昌 yang si chang) хаанд бичиг өргөн мэдүүлжээ. Уг бичигт цай, даавуу, будаа, гурил зэрэг чухал хэрэгцээтэй бараагаар халхын адууг худалдаж авах саналыг дэвшүүлэв<sup>9</sup>. Мөн удалгүй 2-р сард Ян Сычан дахин өргөсөн бичигт:

*Хаанд өргөсөн бичиг. “Түшмэл би 2-р сарын 24-ний өдөр гарч Шахууд хүрэв. Үүний дараа Бугийн (卜部 bi bu Түмэд) Бошигтоор (卜 bu) удирдуулан Хаму (哈目 ha tu Халх) худалдаачид ирж агтаа худалдсан болой. “Түмэдийн элчийг хүлээн авч уулзав”. Тэнгэртэг хаанд мэдэгдэж захидал илгээв. Танай дээдэс Алтан хан 60 гаруй жилийн турш үнэнч шударгаар дагаж, чин сэтгэлээ зориулж зүтгэсэн болой. Эдүгээ бас Халх аймгийн хүмүүс адуу өргөн барив. Би энэ тухайгаа эзэн хаанд айлтгаж, хаан тэнгэр өршөөл нигүүлслээ үзүүлж, та бүхэнд цай, торго, гурил, будаа өгч амь залгуулсан бөлгөө. Та нар ачийг мэдэж тусыг хариулах ёстой хэмээжүй”.*

<sup>5</sup> 《十七世纪俄中关系》第一卷第一册，第38号文件，第141-142页。

<sup>6</sup> 《监视宣大镇太监王坤题本》，崇禎六年正月二十三日，内称：“大同屡报插首已赴归化城索赏，奉旨 拒绝矣。”见国立中央研究院历史语言研究所编：《明清史料》甲编，第八本，1930年，第748-739页。

<sup>7</sup> 《崇禎实录》卷5，崇禎五年八月丁丑；卷6，崇禎六年五月壬寅、壬子，六月丙寅，十月癸未。

<sup>8</sup> 见崇禎八年正月十二日兵部题行《兵科抄出宣镇监视王题》稿《兵部为夷情事》，见中国科学院编：《明清史料》丁编，第五本，上海商务印书馆，1951年，第422页；崇禎八年正月初九日兵部题行《宣府巡抚陈新甲塘报》稿，同前第424页。

<sup>9</sup> 杨嗣昌：《请定市马茶米面疏》，崇禎八年正月二十一日，《杨文弱先生文集》卷7，载王锺翰主编：《四库禁毁书丛刊》集部第69，第121页，北京出版社，1998年。

*Түмэдийн элч хариу хэлсэн нь.* “Эзэн хаан тэнгэрийн өршөөл нигүүлсэлтэй билээ. Бидэнд тусалж өгнө үү хэмээн гуйж, хилийн боомтоо өдөр бүр нээж байхыг хүсмүй. Ингэвээс бид нарын амьдрал амархан оршин тогтнох болой. Хэрэг явдал гарвал даруйхан бидэнд мэдэгдэж болно” хэмээн айлтгав.

*Түшмэл миний бие хариулсан ану, за тийм бөлгөө.*

*Танай Түмэд (er bu) Халхын (ha er) хоёр аймаг хаан эзэнд бичиг өргөж, тэнгэрийн ивээлээр боомтыг нээж авран тэтгэхийг хүлээмүй. Та нарын хэрэг зөвхөн хааны нигүүлсэнд багтана. Хэрэв өөр аймгийнхан ирвээс, тэднийг огт хүлээн авахгүй буюу худалдаанд оруулахгүй, өлбөрч үхвэл сайн болой. “Үүнийг сонссон аймаг овгийн ахлагчид бүгд сөгдөн мөргөж хэлэв. Тэр ахлагч, (目ти) Жаа тийм бөлгөө хэмээв”.*

*Түшмэл би тэднийг шагнаж, арван даавуу, олон нэхмэл, цай нэг зуун уут, дөрвөн хонь, архи хоёр ваар, боорцог 1000 гаруй өгөөд буцаав. Дараа нь хилийн хамгаалагч Лю Жя (刘家) мэдээлэл хүргэж ирэв: Цахарын Тайху хатны иргэн болох Нямсамбуу хэлсэн нь “Бид ямар нэгэн үймээн гаргасангүй, хэрэг өдсөн зүйлгүй атал яагаад биднийг зах руу орж арилжаа хийхийг зөвшөөрөхгүй байна вэ? гэлээ” Лю ноён хариу хэлсэн нь “Зөвхөн адуу худалдахаар ирсэн тохиолдолд арилжаа хийхийг зөвшөөрнө” хэмээн хариу мэдэгдэв. Тэдний отгийн төлөөлөгчид өгүүлрүүн: Зах дотор зөвхөн халх адууг худалдаалахыг хүлээх ёстой гэсэн тул бид урьдчилан хүмүүсээ илгээж замыг хааж зогсмуй ... Дараа нь би зүүн тийш хөдөлж, Датуны зүүн цэргийн хилд хүрч түр саатаж нөхцөл байдлыг ажиглав. Хилийн хотыг шалгаж нээгдсэнээс хойш нийт 1530 халх адууг худалдан авчээ. Төлбөрийг мөнгө болон бараа тааваараар тэнцүү арилжаалмуй. Адуу бүр дунджаар 14-15 лангаар үнэлэгдсэн болой. Худалдан авсан адууны 90 орчмыг цэргийн хуаранд тараасан. Энэ нь цэрэгт ашиг тустай харин нэг, хоёр настай, хөгшин, эмгэг, яндан зэрэг адууг нүүсний наймаачинд өгч тээжээж таргалуулсны дараа дахин борлуулах, үзмэрийн уналга эдэлгээнд ашиглахаар шийдмүй. Ерөнхийд нь хэлбэл, манай Мин улс нэг адууг ч илүүтэйгээр худалдан авах нь хилийн гаднах дайсны нөөцөнд үлдэхээс зайлсхийж чадах сайн хэрэг юм. Гэвч Цахарчууд халх хүмүүс адуугаа авчрахыг сонсоод элч илгээн эхлээд цэргээр сүр үзүүлж, эд хөрөнгө, мөнгө нэхсэн ажээ. Бас тэд, алт мөнгө, торго зэрэг үнэт зүйлсээ халхчуудад зориулан дэлгэн үзүүлсэн нь хятад цай, даавуунаас илүү үнэд хүрнэ гэдгийг харуулахыг оролдсон болой. Халх худалдаачид энэхүү сүрдүүлгээс эмээж, мөнгөний сонирхолд татагдаж, зарим адуугаа Цахар аймгийн төлөөлөгчдөд зарахаар шийдсэн бөлгөө. Тэд манай нутгаас мөнгө болон бараа тааваар бүрэн цуглуулсны дараа буцах болов. Гэвч Цахар аймгийнхан замд нь нэг ламыг алж, цай, даавуу бусад зүйлсийг дээрэмдсэн болой. Иймээс халхчууд үлдсэн адууны ихэнхийг буцаахаас гадна түрэмгийллийг эсэргүүцэх ёстой хэмээн тооцсон ажээ. Ийнхүү Халх, Цахарын хоорондын үл ойлголцол эндээс эхлэв. Эдүгээ үед халхчууд олон тооны адуу туун ирж буй сураг гарчээ. Хэрвээ тэд уулсын цаана байрласан бол гол зорилго нь Цахар аймагт хүндрэл учруулахгүй байхыг хүссэн. Харин Цахар бас Мин улсын нууц цэрэг гэнэт довтлохоос эмээж өдөр бүр майхнаа нүүлгэж, нааш цааш олон удаа хөдөлж, тогтуун бус байна... Халхчууд адуугаа худалдаадаа тэдний худалдаачид зах руу орохгүй зөвхөн Түмэдийн Бошигтоор үнэ тогтоолгон адуугаа хөтөлж авчирч шууд арилжсан болой.*

*Халхын худалдаачид эхлээд мөнгө шаардаагүй, харин дараа нь Мин улсын тушаалыг дагаж мөнгө, барааг тэнцүү хуваан төлөхөөр тохиролцсон бөгөөд тэд ч гэсэн үүнийг дагаж мөрдмүй. Ер нь халх монголчууд хувцас өмсөхдөө таван өнгийн солонгорсон хээг хамгийн ихээр эрхэмлэн хэрэглэнэ. Тэд өмнөх жилиүүдэд авч байсан*

шагналын торгоны даавууг дахин шаардахад, нөгөө худалдаачид энэ тухай сонсоод торго дурданг даруйхан авчирч наймаа хиймүй. Энэ торго “Үнэндээ чанарын хувьд нэн сул дорой, бараг хэрэглэх үнэгүй задгай торго”. Тийм хэдий ч эдгээр торгыг торго зарах нэрийн дор оруулдаг тул хориотой гэдэг хууль тогтоомжийг зөрчихөд хүргэж болзошгүй бөлгөө. Иймийн тул уг байдлыг үнэнээр дээд газарт мэдүүлж тайлагнах нь зүй ёсны хэрэг буй за.

Хэрэв тэнгэрийн нигүүлсэнгүй хаан зөвшөөрвөл, Сюаньфү Датуну цэргийн агуулахад хадгалагдаж буй торго даавууг шалгаж үзээд гаргаж, морь худалдан авч болмуй. Ингэснээр зэс, алт зэрэг үнэт эдлэлийн дутагдлыг нөхөж болмой. Энэ адууны худалдаа долоон жилийн турш хаалттай байсан тул Мин улсад адууны хомсдол тулгараад байв. Харин эдүгээ гэнэт монгол адууны худалдаачид олноороо хүрэлцэн ирсэн нь үнэндээ тэнгэрийн хишигт нийцсэн, зөв цагт тохиосон боломж болой. Мөхөс би гурван хилийн бүсийг хамаарч буй бөгөөд алба үүргээ биелүүлэхгүй байх эрх надад огт байхгүй билээ. Би хил орчмыг шалгахад өнгөрсөн жил Сюаньфү Юнжэньд (云) хууль ёсны худалдаа нээгдээгүй үед хилийн цэргүүд даавуу, цай, мөнгөн ус, тамхи архи зэрэг хатуу барааг худалдаадаг байсныг тухайнд үед нь олж нарийвчлан тэмдэглэжээ. Энэ нь Сюаньфү Юнжэньд зах нээгдээгүй үед ч нууцаар худалдаа хийж хууль бусаар бараануудыг гаргаж байсныг нотолмүй. Ийм явдлыг нотлох баримтаар баталж болохын нэгэн жишээ болой.

Чунжэний тавдугаар он (1632) дайснууд Сюаньфү хил орчимд ирж худалдааны эрх авах талаар ярилцсан бол Их хааны долдугаар онд (1634) шууд Сюаньфү болон Шаньси (山西) руу халдсан. Тэр үед зах нээгдээгүй байсан тул хэн зуучилж худалдааг хийсэн нь тодорхойгүй. Иймээс тогтсон замыг давтамжтай ирж ажигласан тул тэд эхлээд ямарч зуучлагч шаардаахгүйгээр ирсэн. Энэ үйл явдалд тулгуурласан хоёр дахь нотлох баримт боллоо-----<sup>10</sup>

Бодрол бичиг дэх, Ша хү (杀虎口 sha hu) гэдэг үг нь бар алах гэсэн утгатай. Эрт үедээ харийн цайзыг устгах “杀胡堡” эсвэл харийн хаалгыг устгах боомт “杀胡口” гэсэн үгнүүдээр хэрэглэж байгаад Чин улсын үед тус үгийг бар гэдэг үгээр сольж Барыг устгах боомт нэртэй болсон. Бу бү аймаг 卜部 bu bu (卜失兔汉部 bu shi tu han bu boshigt han ) гэдэг нь Хөх хотын Түмэдийн нэг салбар хэсэг юм. Бу му (卜目 bu mu) гэдэг нь Түмэдийн бошигт буюу өөрөөр хэлбэл толгойлогч гэсэн үг. Харин Ха му (哈目 ha mu) гэдэг нь говийн арын халх аймгийн тэргүүлэгчдийг илэрхийлжээ. Түмэдүүд Лигдэн хаантай нэгдсэний дараа Мин улстай албан ёсны алба гувчуур, худалдааны харилцаагаа хараахан сэргээгээгүй байв. Гэвч Мин улс аль хэдийн Халхын язгууртнуудыг татан худалдаа хийхийг зөвшөөрсөн байна. Ян Сычан ийн өгүүлрүүн: “Энэ худалдааны боомт 7 жил нээгдээгүй”. Иймээс халхчууд Лигдэн хааныг баруун тийш нүүдэлснийг сонсоод даруйхан худалдаа хийхээр иржээ. Харин Мин улс Цахарын үлдэгдэл цэрэгтэй худалдаа хийхийг зөвшөөрөөгүй, зөвхөн халхчуудтай худалдаа хийхийг зөвшөөрчээ. Чунжэний 5 дугаар он буюу 1632 онд дайсан Сюаньфүгийн хилийн дэргэд ирж худалдааны эрхийг нэхэмжилсэн хэмээн тэмдэглэжээ. Энэ нь угтаа бол хожуу Чин улс Цахар руу гэнэт довтлох үеэр Сюаньфүгийн ойролцоо ирж Мин улсаас Цахарт

<sup>10</sup> 杨嗣昌: 《边情疏》, 崇祯八年二月二十八日, 《四库禁毁书丛刊》集部第 69, 第 123-125 页。

олгодог жилийн тогтмол шагнал болон худалдааны эрхийг шаардсан хэрэг болно. Янсычан дурдахдаа, зах нээхгүй байсан ч бас хувийн арилжаа болон худалдааны эрх гуйх явдал өрнөж буй тул худалдааг нээж, зохицуулалт хийх хэрэгтэй хэмээн үзжээ.

1635 оны (Тэнгэрийн цэцэний есдүгээр он) 2-р сард хожуу Чин улсын Доргон (多尔衮, duo er gun 1612-1651), дөрвөн бэйл нарын удирдсан цэрэг Цахарын Лигдэн хааны хүү Эжэйхонгорын зүг хөдөлж Шар мөрөнд байх үед цэрэглэн очиж буулгаж авсан<sup>11</sup>. 5-р сард Доргон болон дөрвөн бэйл Хөх хотх руу буцах үедээ Мин улсын Шаньси мужийн бүс нутгийг дээрэмдсэн. Бэйл Юдү (贝勒岳托 bei le yu te) хөлний өвчний улмаас Хөх хотод үлдэж, олзолсон Цахар аймгийн иргэдийг сахин харахаар болжээ. 7-р сард нь Юдү Түмэдүүдэд элч илгээн халхчуудыг Мин улсын худалдаанд татан оруулсныг олж мэдээд даруй цэрэг илгээж таслан зогсоосон ба халхчууд энэ мэдээг сонсмогц оргон зайлжээ. Түмэдийн 10 хүн, Мин улсын 4 элч, Үзэмчиний 46 хүн, тэдний худалдаачдын авч явсан адуу, тэмээ болон арьс ширийг бүгдийг олзолж хураан авчээ. Юдү өөрийн дур зоргоор авирлаж Халхын худалдаанд оролцож, Мин улстай харилцсан төдийгүй Түмэдийн захирагч зайсан Маохан (宰桑毛罕) -ыг цаазалжээ. Бас Түмэд аймагт шинэ захирагч томилж, Түмэдийн бошигт хааны хүү болон Алтан ханы тамгыг Мүгдэн хотоос буцаан авчирсан байна<sup>12</sup>.

Доргоны удирдсан Чин улсын цэрэг Мин улсын Шаньси мужийг довтлон дээрэмдэж, тэд цааш үргэлжлэн Пинлу вэйгээр (平虏卫 ping lu wei) дамжаад Цагаан хэрэмд хүрч, тэндээсээ өмнө зүгт Синжөү (忻州 xin zhou), Дайжөү (代州 dai zhou) орж, буцаад Пинлу-вэйгээр дайрч өнгөрөөд хил гарчээ. Элсэн голын цайзад (沙河堡 sha he bao) хүрч Мин улстай худалдаа хийж дууссаны<sup>13</sup> дараа Доргон Юдүтэй уулзаж зүүн тийш буцав. Тэр жилийн 5-р сард Манжийн захиргаа баруун тийш байлдах цэргийн ажиллагаанд хамтрах үүднээс харчин тайж, тавнан нарыг Мин улсын Тяньжинь хотод илгээж урьд нь авч байсан худалдааны эрхийг шаардсан. Энэ нь Мин улсын баруун бүс нутагт өгч байгаа тусламжийг хязгаарлах зорилготой байв<sup>14</sup>.

1636 оны (Тэнгэрийн цэцэн хааны аравдугаар он) 2-р сард Чин улсын зүгээс Цагаан лам тэргүүтэй найман хошууны хүмүүсийг булганы арьс, хүн орхоодой зэрэг зүйлсийг авч Шаху боомтод очиж худалдаа хийхийг даалгасан<sup>15</sup>. Дээд эрдэмт хааны эхний жил буюу 1636 оны 7-р сард (Мин улсын Чунжэний есдүгээр он), Түмэд аймгийн Хүлэгчухур Мүгдэн хотод ирж алба өргөн буцах үед Чин улсын төрөөс түүнд Бошигт хааны хүү болон Бошигт Алтан ханы тамгыг авч явахыг зөвшөөрсөн. Мөн Эрдэнэдархан Нансун ламыг хошуу бүрээс

<sup>11</sup> 《清太宗实录》卷 22, 天聪九年二月丁未.

<sup>12</sup> 《清太宗实录》卷 24, 天聪九年八月庚辰.

<sup>13</sup> 《清太宗实录》卷 24, 天聪九年八月庚辰. 从后金军北返路线来看是杀胡堡, 《清太宗实录》中音译为沙河堡.

<sup>14</sup> 《清太宗实录》卷 23, 天聪九年五月癸亥、六月癸未.

<sup>15</sup> 《清太宗实录》卷 27, 天聪十年二月庚寅.

хоёр хүн дагуулж явахыг тушаав<sup>16</sup>. Ингээд Хөх хотын Түмэд аймгийнхан Алтан ханы нэрийн дор Мин улстай хоёр талын худалдааны харилцааг сэргээж, Мин улсын худалдааны боомтыг хянах боломж бүрджээ. Мин улстай дайн эхэлснээс хойш Чин улс тэдэнтэй худалдаа наймаа хийж чадахгүй болж өөрсдийн нутаг дэвсгэр дахь өдөр тутмын зайлшгүй шаардлагатай даавуу, торго, гар урлалын зэрэг бүтээгдэхүүний их хомсдолд орж, булганы арьс, хүн орхоодойг борлуулах зах зээлгүй болжээ. Ийм учраас Мин улстай зайлшгүй худалдаа хийх хэрэгцээ тулгарчээ. Тэр жилийн 11-р сард Сюаньфү, Датун ерөнхий захирагч Лу Сяншэн (卢象升) бичгээр мэдүүлсэн нь:

*Датун мужийн хилийн захирагч, баруун гарын орлогч хааны хяналтын түшмэл, одоо гурван зэрэг буурч гэм буруугаа үүрч буй албан хэрэг хариуцагч Е Тин-гүэй Тангаас (叶廷桂塘) айлтгал өргөн мэдүүлсэн бичиг.*

*Урьд нь Түмэд (Бу И 卜夷) аймаг нь Цахар (插 cha) аймгийг хамт байхыг харсан ану. Эдүгээ Цахар аймаг Ну 奴 ni (Манж нар) аймагт дагаар оржээ. Сүүлийн жилүүдэд зүүн зүгийн Зүрчид болон Цахар, Түмэд нар нэгдэж хил рүү халдаж байгаа билээ. Тэд Манжид дагаар ороод зогсохгүй бүр тэдэнд үйлчилж баймуй. Одоогийн байдлаар Түмэдийн бошигт Сэнжим тайж (省吉木)<sup>17</sup>, мөн Чүнгэн (忠义) хатны ач хүү Намур (那木儿) тайж<sup>18</sup> нар гэнэтхэн дагаар орж үнэнчээ илэрхийлэх өргөдөл ирүүлбэл, магадгүй биднийг турших гэсэн заль мэх байж болзошгүйг сэрэмжилмуй. Эс бөгөөс Манж нарын шахалтаар ирсэн байж болзошгүй. Энэ бүхэн одоогоор тодорхой бус байна. Иймд хилийн түшмэд яаралтайгаар дайны хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлмуй. Тэнгэрийн энэ тааллыг биелүүлэх ажаамуй. Хэрэв Түмэд, Цахар зэрэг харь аймгууд Зүрчдэд хүчин зүтгэж байгаа бол тэднийг өөрийн талд татан оруулж ашиглах нь илүү дээр, үнэнд эргэлзэх саналгүй болой. Гэхдээ эдгээр нүүдэлчдийг өөртөө урвуулан ашиглахыг хүсвэл эхлээд тэднийг бүрэн захирч, бие сэтгэлийг нь хүртэл удирдах хүч надад байх ёстой бөлгөө. Эдүгээгийн нөхцөлөөс харахад ийм чадал байгаа эсэхийг хэлж мэдэхгүй. Одоо Шаху (杀胡口 sha hu kou) боомтод адууны зах зээл шинээр нээгдэв. Иймд хилийн хянан захирагч Е Тин-гүэй, цэргийн жанжин Ван Пу-е (王朴业 wang pu ye) нар эзэн хааны зарлигийг дагаж тус газарт очиж, хяналт тавин үймээн самууныг зохицуулах ажлыг хийвэл гэнэтийн санамсаргүй алдаанаас зайлсхийж чадах буй за. Тэдний бууж өгч дагаар орох асуудлын тухайд, өчүүхэн миний бодлоор бол нэг талаас төрийн сүр хүч ивээлийг үзүүлж, тэднийг тайван захирах хэрэгтэй. Нөгөө талаас тэдний үнэн сэтгэл, худал байдлыг нууцаар нарийн шалгаж, бодит нөхцөлд тохируулан нийцүүлэх нь зүйтэй бөлгөө<sup>19</sup>.*

<sup>16</sup> 《清太宗实录》卷 30, 崇德元年七月乙丑。

<sup>17</sup> 原方框内缺文应为奴字, 明代对后金的鄙称, 清代为避讳而省字, 空两个方框的应为“东奴”二字。

<sup>18</sup> 《钦定蒙古回部王公表传》中记博硕克图汗子名为俄木布, 见包文汉、奇·朝克图整理: 《蒙古回部王公表传》第一辑, 卷 112, 《土默特辅国公喇嘛扎布列传》, 内蒙古大学出版社, 1998 年, 第 710 页。

<sup>19</sup> 卢象昇: 《卜夷乞款疏》, 《卢肃公文集》卷 5 《宣云奏议》, 清光绪元年 (1875 年) 卢氏家祠刻本, 第 19 页。

Энэхүү захидлаас харахад Хүлэгчухур (gu lu ge chu hu er) буцаж ирснээс хойш, Эрдэнэдархан Нансун лам нар хамтран Мин улстай харилцаж, Алтан ханы нэрийн дор Түмэд аймаг, Мин улсын худалдааны харилцааг сэргээхийг оролджээ. Мин улсын хил хязгаарын ноёд энэ талаар хааны захиргаанд мэдэгдэж, худалдааны харилцааг дэмжих санаа агуулсан байна. Үүний дараа Лу Сяншэн 11-р сард дахин өргөдөл бичиж, нэмэлт тайлбар санал гаргасан байна.

*Энэ сарын зургааны өдөр гаргасан эзэн хааны зарлигт: “Түмэдийн хоёр аймаг аль хэзээний Манжид дагаар орсон атал энэ удаад морь худалдах шалтгаар далимдуулан гэнэт хил сахихыг хүссэн болой. Үүнд гарцаагүй ямар нэгэн булхай санаа бий бөлгөө. Нүүдэлчдэд илгээсэн зарлигт дэлгэрэнгүй дурдсанаар, харийн аймгуудыг зарлан мэдэгдэх нэгэн зүйл: Их цэргийн ерөнхий жанжин эзэн хааны зарлигийг даган Алтан ханы удам бошигтын хүү, тайж Сэнжим мөн Чүнгэн хатны ач хүү Намур тайж нарт хандан тушаамуй. Танай Чагур тэргүүтэй хорь гаруй хүн хилийн ханын доор хурч ирээд, тэнгэрийн хаанд үнэнчээр дагаар орж, хилийн хана хэрмийг сахин хамгаалахад бэлэн гэдгээ бичгээр уламжлав. Бас түмэн наст хаан өвөг эцэг Алтан ханы хуучин тамга эх хувийг итгэмжлэл болгон авчирсан нь та нарын үнэн сэтгэл, ачийг ачаар хариулах хүсэл илт харагдаж баймуй. Анхандаа танай гэр бүл үнэхээр сайн хүмүүс байсан боловч Зүүн манжууд цэргээ илгээж нэгтгэж авна гэхэд та нар хол дутаан оджээ. Сүүлийн үед та нар халх адууг авчирч зах зээлд худалдах болсон. Энэ нь та нарт ихэд ашигтай байгаа..... Хэрэв манай засагт үнэн сэтгэлээр дагахыг хүсэж байвал эхлээд манжуудын хэрэг явдлыг нэг бүрчлэн бүгдийг нь урьдчилан илтгэх ёстой. Дараа нь Баруун, Зүүн халх аймагт хандаж хэл. Тэд нарт Тэнгэрийн хаан төрийн өмнө чин сэтгэлээсээ хүлцэнгүй, хүндэтгэлтэй дагахыг сургагтун. Хэрэв манжуудын нэг хүн, нэг адуу манай улсын Сюаньда (宣大) болон Шаньси хилд ирвэл, та нар нэг талаас ирж мэдэгд, нөгөө талаас бүх хүчээ дайчлан хил хязгаарыг хамгаалж байтугай. Зөвхөн ингэж байж л та нарын чин үнэнч байдал илт болж Тэнгэрийн хаан чамйг зовоохгүй байх бөлгөө. Энэ бол миний илгээсэн албан бичиг юм<sup>20</sup> хэмээн явуулав.*

Чагур (朝库儿 chao ku er) гэдэг нь Түмэдийн захирагч Хүлэгчухурыг хэлж байна. Тэр Мүгдэн хотоос Алтан ханы тамгыг авчирч итгэлцлийн баталгаа болгож, Мин улсын хилийг сахин хамгаалах нэрээр тэдэнтэй худалдааны асуудлаар хэлэлцжээ. Мин улс зүүн, баруун халх (зүүн халх, баруун халх) аймгуудыг адуу худалдахаар ирэхийг уриалан дууджээ. Мөн тэднийг Манжийн тухай нөхцөл байдлыг дамжуулж байхыг тушаажээ.

Лу Сяншэн дахин өргөн айлтгасан ину:

*Түмэд аймгийн олон ноёд Тэнгэрийн хааны аврал ивээлд 60 гаруй жил амьдарч ирэв. Ойрмогхон Цахарын шахалтад орж, амь насаа Зүрчидэд даатгаж, өнөөдөр бол үнэндээ өнчирсөн дэгдээхэй, өмхий хулгана төдий болжээ. Тэд өлсвөл хүн дагах ба нэг өдөр хил дээр ирж энхийн хэлэлцээр гуйх буй. Тэднийг манжуудад ашиглуулахын оронд бид үйл хэрэгтээн татаж оруулах нь илүү сайн болой. Би өмнөх хоёр*

<sup>20</sup> 卢象昇:《遵旨谕誓卜夷疏》,《卢肃公文集》卷5,第29-30页。

өргөдөлдөө тэд нарыг мал адгуус мэт ааштай, зан нь тогтворгүй, аль талд орох нь тааварлашгүй, Зүрчидийн нөлөөнд орж болзошгүй хэмээн тэмдэглэсэн билээ. Иймээс хилийн захирагчдад тус бүр орчуулагч түшмэлийг илгээж захирамжийг хүргүүлэв. Үүний үр дүнд хоёр аймгийн ахлагч өөрийн харьяатаа дагуулан хил дээр ирж толгой бөхийлгөн, үнэнчээ илэрхийлж дагаар ормуй. Тэд хутга барьж аман тангараг өргөж, өөрийн хүслээр хил хамгаалахаар болмуй. Зарим үед Халхын адууг авчирч Мин улсын захад худалдах нь тэдний бодит байдал бөгөөд надад захирагдах болмуй. Өнөөдөр бид Түмэд, Халхыг ашиглаж, тэднийг эвсүүлэн Зүрчидийн эсрэг зогсох стратегийн боломж оршиж баймуй. Барагцаагаар тэд өөрсдөө зальжин санаатай. Манай хилийн захирагчид ямар ч овгийн ноёд буулт хийж, суларч дордох ёсгүй. Үүнээс гадна хилийн зурвас хэдэн мянган ли урт, стратегийн чухал боомтууд хэдэн зуу ли зайд байрлаж байна. Харуулын ангийг байцаалтаар илгээх бүрдээ 100 ли газар хүрэхгүйгээр буцаж ирнэ. Заримдаа хүн морь гэмтээж эргэж ирж чадахгүйд хүрнэ. Иймд хил хамгаалалт болон бусад аймгийн халдлага зэрэг хүчин зүйлсэд Түмэдийг ашиглах нь тохиромжтой. Бид тэр жил Манжид татвар өгөхөөс зайлсхийж, засгаас жил тутмын зардал олгоогүй, дипломат харилцаанд их зардал гарсан, хилийн түшмэдийн гарт ганц ч мөнгө зарцуулаагүй. Мөн харийн хүмүүс ирж дагах болсон нь хааны сүр хүч нөлөөг дуулмуй. Цэрэг улс төрийн бодлогыг явуулахдаа амархан амлалт өгч, шагнал тараах зохимжгүй. Эхний жилд тагнан мэдэж аваад хилийн газрыг саадгүй болгож, үнэхээр манай улсын төлөө хүчин зүтгэх нь баталгаажсаны дараа шагнал олгох асуудлыг хэлэлцмүй. Хоёр жилийн ар дээр шагнал нэмэгдүүлэх болон гурав, таван жилийн дараа хуучин эзэмшил, хэргэм зэргийг сэргээх тухай авч хэлэлцэх болой. Одоо бол өөрсдөө харьяат болохоор хаалганд ирж мөргөх хийгээд Манжийн нөхцөл байдлыг тагнаж мэдээлэл өгмүй. Бид хэмжээг тохируулан улаан торго, архи, хоол хүнс олгож хааны сүр хүч, нигүүлслийг ойлгуулмуй. Эзэн хаан мэргэн ухаанаа уралдуулан, ордонд сууж буй түшмэдүүдийн хамт хэлэлцэж, шийдвэрээ тогтоомуй. Нууц зарлиг буулгасны дараа бид нар мөрдөж хэрэгжүүлэх болой. Бас дахин нэг удаа хааны зарлигийг Түмэд аймаг руу явуулсан. Ингэснээр хүмүүс хааны шагнал ивээлийг хариулахыг эрмэлзэж, дээдсийг хүндэтгэж сэтгэл нь улам хүлцэнгүй тайван болмуй. Харин тэдний зальжин ахлагч хааны захиргаанд дагаар орж буй энэ үеийг ашиглан, нөхцөл байдалд тохируулан урьд цагт олзлогдсон бүхий л харь хүмүүсийг хүч хэрэглэхгүйгээр заримыг нь сулламуй. Хааны засаг, энэрэл итгэлцлийг бага зэрэг үзүүлэх нь эрх мэдлийг зохицуулах, удирдах нэг арга хэлбэр мөн. Хэрэв Манжтай байлдахад хурвал, Түмэд, Халх нараар тэд нарын хүчийг хязгаарлан барьж, Сюаньюны газраар давшилтыг хамгаалж дайны нөхцөлд шилжнэ. Дараа нь дайны иж бүрэн бодлогыг хэрэгжүүлэх асуудал нь тактикийн хувьд нэн нууцлаг байна. Иймд зохион байгуулалт олон байгаа тул бичгээр бүгдийг өгүүлэх боломжгүй учраас түшмэл би хаантай уулзахыг хүссэн илтгэл тайлбар энд байна<sup>21</sup>.

Чуньчэн хааны 9 дүгээр он, 12-р сарын 15-нд болой. Сюаньфү, Датун хилийн тайван байдлыг хамгаалахын тулд Лу Сяншэн Мин улсын захиргаанд Түмэдтэй харилцан худалдааны хүсэлтийг зөвшөөрөхийг зөвлөж, “Халх, Түмэдийн харилцаанд Манжийг хязгаарлах” санааг дэвшүүлжээ. Ингээд Мин улсын засгаас зөвшөөрөл авчээ. Түүнчлэн Чин улс Түмэдээр дамжуулан Мин

<sup>21</sup> 卢象昇：《密奏卜夷纳款疏》，《卢肃公文集》卷 5，第 37-38 页。

улстай шууд бусаар худалдаа хийх боломжтой болжээ. Цаашид түмэдүүд Мин улсын хил орчмын халдлагаа зогсоосон бөгөөд Мин улсын хилийг хамгаалах амлалтаа хэрэгжүүлсэн. Мин улсын Сюаньфү болон Датуны түшмэд хил хязгаарыг хэсэг хугацаанд тайван байлгахыг зорьж байв. Харин Түмэд, Манжийн харилцааг судлаагүй үл хайхарчээ.

## ХОЁР

Халхын талаас Цэцэн хан, Мин улстай худалдаа хийхээр илгээсэн элч нарыг Чин улсын цэрэг дээрэмдсэний дараа Тэнгэр цэцэний 9 дүгээр оны (1635) 2-р сард Чин улсад элч илгээж эелдгээр урьдчилан сануулж анхааруулжээ<sup>22</sup>. Тайзу хаан Цэцэн ханы элчийг буцаан илгээж, мөн айлтгал зарлиг бичжээ. Үүнд:

*Тэнгэрийн цэцэн хаан Халхын Цэцэн ханд айлтгах ину: “Чи урьд энх тайвны замыг эрж, өөрийн мэргэн ухаанаар шүүнэ” хэмээн хэлсэн туйлын үнэн бөлгөө. Би мэднэ. Бүх улс орныг байлдан дагуулахад нэр алдарт хүрдэггүй, тэнд зөвхөн ашиг хонжоо бодсон хүмүүс байдаг. Мин улс урьд нь надтай өшөө хорсолтой байсан тул цэрэглэн хөдөлж довтолсон. Тэр даруй Цахарын хаан Мин улсаас эд баялаг авч, цэргийн тусламж үзүүлсэн. Тийм болохоор би гэм бурууг яллаж довтолохоор шийдэв. Тэнгэрийн ивээлээр Цахарыг буруутай гэж үзсэн агаад тэд миний талд орвой. Чи бас адууг Мингийн хүмүүст заржээ. Яагаад Мин улсад тусалж, эд баялаг авахаар шунав. Чи ийм буруу үйлдэл хийсэн, гэсэн ч би түүнд сэтгэл зовохгүй, эвлэрэх зохицуулах асуудлыг зөвхөн таны хариу мэдээгээр шийдвэрлэтүгэй<sup>23</sup>.*

Тайзун хаан Чингийн цэрэг Халхын Цэцэн ханы худалдаа руу гэнэт дайрсан явдалдаа уучлалт гуйсангүй. Харин Мин улсад морь худалдахгүй байхыг Халхын Цэцэн ханд анхааруулжээ. Сюаньфү хотын захирагч Чэн шин жя(chen xin jia)-ийн илтгэлд:

*Мөн нягтлан шалгаж үзвэл тус нүүдэлчдийн мэдүүлгээр: (Чунжэний 8 дугаар он. 1635) 12-р сард баруун халх аймгаас зуу шахам хүн, зуун адууг хамтад нь илгээж дөрөвдүгээр хан хөвгүүнд хүргүүлсэн. Түүнчлэн хоёр тал харилцан элч солилцож, харилцан эв найртай байхыг хүсэж байгаагаар аль аль талд мэдэгджээ. Дөрөвдүгээр хөвгүүн нь их хэмжээний мөнгө авч 300-400 орчим хүн илгээсэн, Чунжэний 9 дүгээр оны (1636) 3-р сарын 1-нд уулын араас чимээгүйхэн баруун тийш хөдөлж, бараа худалдан авахаар явжээ. Бас дөрөвдүгээр хөвгүүн 3-р сарын 3-нд дахин өөрийн зүгээс 100 хүн илгээж, өмнөх удаад адуу хүргэж ирсэн халхын зуун хүн, мөнгөний хамт Баруун халх аймагт хүргүүлжээ. Мөн зарлиг гаргаж явуулсан харь хүн халхчууд дээр очоод тэдний ноёд хэлүүлэв. Адууг зөвхөн бидэнд худалдахыг зөвшөөрнө, харин өмнөд Мин улсад худалдахыг хориглоно хэмээжээ<sup>24</sup>.*

<sup>22</sup> 《清太宗实录》卷 26, 天聪九年十二月癸未。

<sup>23</sup> 《清太宗实录》卷 27, 天聪十年二月丁丑。

<sup>24</sup> 《兵部题为哨探事》，崇祯九年四月初五日，兵部题 《宣府巡抚陈新甲塘报》，《明清史料》甲编，第九本，第 853 页。

Дөрөвдүгээр хөвгүүн ханхүү бол угтаа Чин улсын Тайзун хаан юм. Дээр дурдсанчлан, Чин улсын зүгээс Түмэдийг Мин улстай хил сахин хамгаалах гэрээ хэлэлцээр байгуулж, худалдааны боомтыг хяналтдаа оруулах зарлиг буулгажээ. Түүний зэрэгцээ халхчуудыг шууд Мин улстай худалдаа хийхийг хязгаарласан байна. Дээд эрдэмт хааны эхний оны (1636) 11-р сард Чин улсын элч зайсан Вэй ба бусад халхын тусгай элч болон худалдаачид нийт 156 хүнийг дагуулан Чин улс руу буцав<sup>25</sup>. Цэцэн хан Чин улсын Тайзун хаанд хариу захидал өгүүлрүүн:

*Махасамади Цэцэн хан хүндэтгэлтэйгээр айлтган мэдүүлэв. Бүхнийг сур хүчээр дагуулсан Тэнгэр цэцэн хаан бид хоёр эв найрамдлын замыг хамтдаа барьж, харилцан элч илгээдэг зарчим нь яах аргагүй эртний бичгийн дээд эрэмбэтэй ёс жаяг мөн. Гэвч Мин улстай хийх адууны худалдааг үл зөвшөөрсөн зарлиг чинь бидний худалдааг хориглохыг завдаж буй. Учир нь Халхын аймаг, долоон хошуу болон Ойрад дөрвөн аймаг бүгд худалдаанд оржээ. Бид мөн адил худалдаанд оролцох болно. Захирагч, тусгай элч зайсан Вэй, халх нарыг багтаасан зургаан хүн байв<sup>26</sup>.*

Цэцэн хан Халх болон Ойрадын бүх аймаг Мин улстай худалдаа хийж байгааг дурдаад, Хунтайж түүнийг зэмлэн буруутгасныг эв зүйгээр зөвтгөв. Халхын гурван аймаг Чин улсын хориг саадыг үл харгалзан, Мин улстай худалдаа хийхээр үргэлжлүүлэн элч илгээв. 1636 оны (дээд эрдэмт хааны эхний он) намар, өвлийн үеэр Баруун халхын элч (ерөнхийд нь бүх халх) Датунд очиж, Шаху боомтод 20 мянга орчим адуу худалджээ<sup>27</sup>. Энэ үед Хөх хотын түмэдүүд Халхын адууны худалдаанд оролцоогүй болохоор халхчууд шууд Мин улстай худалдаагаа хийж эхлүүлэв. Чунжэний 10 дугаар оны (1637) 3-р сард Халхын талаас дахин Сюаньфү хотод элч илгээжээ. Жанчхүүгийн худалдааны боомтод арилжаа хийхийг хүсээд бас баталгаа болгож Чинчэнү (璦琿 jian zhen) хэмээх нэртэй хүнийг үлдээжээ<sup>28</sup>. Үүний дараа 4-р сард Лу Сяншэн хаанд айлтгал өргөн мэдүүлэв.

*Баруун халхын Цэцэнгийн харьяат Хушгайгүй (喚黃古香艾), Хишигт хэмээх хоёр хүн Туулай гэдэг газраас хөдөлж, нэг сар гаруй явж эцэст нь өнөөдөр хүрч ирэв ээ. Ойролцоогоор 200 адуу болон 70-80 тэмээ хөтөлж худалдааны хэлэлцээр хийхээр ирсэн ийм учиртай... Бас Сюаньфүг хянан захирагч Лю Юнцзо (刘永祚)-ийн өргөдөл, Жанчхүүгийн хил хамгаалагч Жоу Хуньюн (周洪猷) -ы мэдээнд тулгуурлан илгээв. Харь хүн болох Цэцэнбаши(七庆把什 qi qing ba shen), Дайцэцэн (歹青恰 dai qing qia) нарын мэдүүлснээр тэд уулаасаа Дайцэцэнгийн харьяат бөгөөд өмнөх жилд энэ боомтод арилжаа хийж, худалдааны эрх хүртсэн харьчууд болой. 1628 онд (Чунжэний эхний он) Цахарын хүмүүс хилд ирж тус аймгийн тайж*

<sup>25</sup> 中国第一历史档案馆、中国社会科学院历史研究所

<sup>26</sup> 译编:《满文老档》下册, 中华书局, 1990年, 第1693-1694页。

<sup>27</sup> 《满文老档》下册, 第1694页

<sup>28</sup> 《兵部尚书杨等谨题为再陈卜哈情形以策安边机穀事》, 崇祯十年闰四月十八日, 兵部题《宣大总督卢象昇题》行稿, 《明清史料》甲编, 第九本, 第875页。

нартай худалдааны боомтын эрхийг булаацалдан, Даланхар уулын ард тулалдаж, Дайцэцэн харьяатын тайж, зайсан зэрэг хоёр хүн гэмтэж, зарим харь хүмүүс нь Халхын ханы дор дүрвэж очжээ. Тэд сүүлийн хэдэн жил Датун, Шаху цайзад адуу худалдаалсан байна. Алтан ханы харьяат иргэд адуу хулгайлснаас болж мөнгөний хохиролд оржээ. Өмнөх жилүүдэд Жанчхүүгийн боомтод худалдаа шударга явагдсан, тэд 200 гаруй морьд хөтөлж зах дээр ирж худалдаалахыг гуйж байсныг сануулмуу. Цэцэнбаши зэрэг хүмүүсийг манай цайз доторх ахмад харуулын түшмэлүүд таньж байгаа ба өмнөх жилүүдэд худалдааны эрх авсан нүүдэлчид мөн болой. Гэвч тэд хилээс холдоод аль хэдийнээ арван жил болсон тул одоо магадгүй заль мэх хуурмаг үйлдэл гаргаж болзошгүй хэмээн сэрэмжлэх шалтгаанаар захиргаанд мэдүүлэв. Олон нүүдэлчид хил дээр ирж дотогш орж, худалдаа хийхийг хүсэж байгаа ч тэдний үнэн санааг ойлгоход бэрхтэйгээ. Хэрэв үнэхээр адуу худалдаагаар ирсэн бол бидэнд их ашигтай юм. Гэвч үнэн худалд итгэхэд бэрх болой<sup>29</sup>.

Мөн Мин Улсын Сюаньфү хилийн хянан захирагч Ли Юнцзо (刘永祚) илтгэсэн мэдээнд:

Хилийн хязгаарын хариуцагч тайган Жэн Ляньфугийн (郑良辅) харь хүмүүсийн өргөсөн бичгийг орчуулан буулгасан мэдүүлэг. “Сюаньфүгийн гурван ноёнд Махасамади цэцэн ханы төлөөлөгч хэлэхдээ хоёр тал их хэрэгт эв найрамдалтай байх ёстой. Урьд жилүүдэд Алтан хан болон их Мин улсын хооронд чухал тохиролцоо байгуулмуу. Хожим нь Цахарын хаан зургаан том аймагтай холбогдож, Өмнөд Мин улс болон Гадаад улсын (Ойрад) харилцааг бүгдийг эвдэж үймүүлжээ. 1635 оны гахай жилээс эхлэн Шаху цайзад худалдаа арилжаалж эхэлсэн. Халхын долоон хошуу Гадаад улсын Алтай дөрвөн аймаг (Ойрад) нар худалдааны их замыг нээсэн тул эдүгээ Сюаньфү хотын том, бага бүх албан тушаалтнуудад боомтоо нээж хоёр тал амар тайвнаар худалдаагаа хийнэ хэмээн мэдэгдэж байна. Гурван түшмэлд хүндэтгэл болгон гурван адуу илгээж, мэнд асуухаар Дайцэцэн, Цэцэнбаши, Бу---(нэр тодорхойгүй) зэрэг хүмүүс ирмүй. Тус мэдэгдлийг яамны хэлтэст хүргүүлсэн агаад тухайн хэлтэс нүүдэлчдийн мэдэгдлийг хянасан. Энэ илтгэлийн бүтэц бүрэн ойлгомжтой бус. Гэвч гол агуулга нь Жанчхүү хотод худалдаа хийх тухай бичсэн бөлгөө. Үүнийг Цэцэнгийн харьяатын харь иргэдийн хүсэлт гэж тэмдэглэсэн ба өмнөх жилийн Алтан ханы хүмүүсийн хэлсэн үгнээс үндэслэн тайлбарласан амуу. Чунжэний 10 дугаар он. 4-р сарын 17-нд<sup>30</sup>

Дээр дурдсан хоёр илтгэлд гарч буй Баруун халхын Цэцэн буюу Махасамади хан гэдэг нь Зүүн халхын Цэцэн Шолой Убаши хунтайжийг нэрлэж байна. Цэцэн ханы тусгай элч Цэцэнбаш өөрийгөө Лигдэн хаан баруун зүгт хийсэн дайн буюу Харчинг нэгтгэж авахаас өмнө Жанчхүүгийн хилийн гадна оршин сууж, худалдаа хийдэг байсан гэж мэдэгджээ. Тэрээр харчин хүн агаад Халхад дүрвэж очжээ. Халхчууд дахин арилжаа наймааны зуучлалыг Хөх хотын түмэдүүдээс авахгүй болсны улмаас Цэцэн хан, түүнийг Мин улстай бараа таваарын солилцоо хийлгэхээр тусгай элчээр томилжээ. Цэцэнбаш нь өөрийн мэдэх Жанчхүүд

<sup>29</sup> 卢象昇:《议覆马市疏》, 崇祯十年九月二十二日,《卢肃公文集》卷8,第19页

<sup>30</sup> □卢象昇:《类报宣直夷情疏》, 崇祯十年四月二十二日,《卢肃公文集》卷7,第25-28页。

ирж худалдааны харилцааг холбож өгчээ. Жанчхүү боомтоос Цэцэн хан аймагт хүрэх зам нь Шаху боомтоос илүү ойрхон. Түүнчлэн Хөх хотын түмэд аймгийн хяналтаас зайлсхийж болдог. Дээд эрдэмт хааны 2 дугаар он (Чунжэний 10 дугаар он 1637) хаврын сүүл сарын 29-нд Сюаньдагийн ерөнхий захирагч Луньшэн санал тавьжээ.

*Тус сайд өнгөрсөн оны 11-р сард Түмэдүүд дагаар орох тухай мэдүүлэг өргөн барьснаар Мин улсын төрийн зааврыг дагаж, тусгайлан нэг хэсгийг хүлээн авч оруулахаар болов. Түшмэл би орон нутгийн түшмэлүүдтэй хамтран тухайн нөхцөл байдал, боломж бололцоонд тааруулан, уян хатан хандсаны үр дүнд өнгөрсөн хагас жилийн турш хил хязгаар амар тайван байлаа. Түүнчлэн хааны сангаас мөнгө огтхон ч үрээгүй буюу өмнөх шиг шагнал өгдөг байдлыг үл харгалзаж, зөвхөн адууны захыг нээж уяран дагуулах бодлого барьсан. Халх адууг зах руу татсан хэрэг нь үнэндээ цэргийн яамны түшмэл Ян Сычан, Сюаньфү газарт хяналт тавьсан үеэс эхлэх ажээ. Өнгөрсөн намар, өвөл Сюаньфүгийн цэргийн хүч тусламжид дайчлагдсанаар Датун хотын хамгаалалт сул болсон ажгуй. Баруун халхчууд хүчирхэг 7-8 мянган иргэдээ дагуулж, 20 мянга гаруй адууг тууж ирээд хилд тулж адуу худалдахыг шаардав. Үүнийг сонссон нутгийн иргэдийн дунд тугшүүр бий болмой. Хил хязгаарын түшмэл Е Тин гүйн хатуу зөөлнийг хослуулж, тайван сандралгүй ухаалаг хандсан тул харь хүмүүс арилжааны захад нэвтрэх хүсэлт ирүүлсэн ану.*

*Ингээд Мин улс үүлэн хээтэй адуун сүргийг хүлээн авав. Түүний энэ үйл ажиллагаа өмнөх захирагчийн бодлоготой харилцан уялдсан хэрэг гэж үзэж болно. Гэхдээ морь худалдаж буй нь Халх аймгийнхан байсан бол Түмэд нар адууны наймааг зуучлах нэрээр мөнгө авах хүсэлтийг надад тавьсан. Харин халхчууд арилжааны захаас ашиг олохыг хүсэж, манай улсад хүндэтгэл үзүүлж, итгэл олох байдал харуулдаг бөлгөө. Засгийн албан түшмэл болон нүүдэлчдийн ирсэн мэдээллээс үзэхэд, Халх аймаг уулаасаа хоёр жигүүрт хуваагдах ажээ. Зүүн халх хүн ам цөөн, сул дорой, нутаг дэвсгэрээр Зүрчидтэй ойрхон. Тэд Зүрчидийг түшидэг бол Баруун халх хүчирхэг, хүн олонтой, Зүрчидээс хол тул эсэргүүцэх чадвартай төдийгүй бага зэрэг тэд нараас болгоомжилмуй. Гэвч Мин улсаас их алслагдмал тул адуу арилжих аялал гурван сар үргэлжилж эцэст нь Сюаньфүгийн хилд ирдэг. Тэд арваад жилийн өмнө Цахарын олон иргэд саад учруулснаас болж бие даасан худалдаа хийх боломжгүй болжээ. Одоо сонсох нь тэд аажмаар зүүн тийш нүүдэл хийж, Сюаньфүгийн хилээс ойролцоогоор 6-7 мянган лид байрласан. Хүн ам нь 20-30 мянга бус, харин 200-300 мянга хавьцаа. Энэ нүүдэл нь Баруун халхын нөхцөл байдал болой. Түмэд аймаг Цахартай нэгдсэн. Гэвч үүний дараа Цахарчууд мөхөж захирагч Сэнгүм, Намур хоёр өөрсдийн хуучин нутаг төрөлх сууриндаа буцан Фэнтайтан, Хөх хот зэрэг газарт оторлон сууж амой. Энэ нь Сюаньфү хилээс ердөө 200-300 ли зайтай байрлаж баймуй. Энэ ноёны аймагт эр, эм хөгшин залуу нийлээд нийт 20.000 хүн баймуй. Тэдний дунд бие бялдар, хүч чадал сайтай 5-7 мянган хүн байдаг бол 1-2 мянган адуу байна. Халхчууд адуугаа авчрах бүрд хоорондоо тохиролцож, адуу бүрээс 2-3 лян хүртэл харилцан адилгүй зуучлалын мөнгө авснаар ашиг олно.*

Тэдний зальжин арга мэхтэй хүмүүс нь халхын сарнисан адууг цуглуулах ба заримыг нь худалдаж аваад зарж зоос олдог. Тэд адууны чанарыг дунд, дээд гэж ялгаж үнийн хөөрөгдөл үүсгэжээ. Ойрын үед Түмэд аймгийн нөхцөл байдал ийм бөлгөө. Манжийн хүчирхэгжилт нь Алтан болон Цагаан (bai) овгийн хоёр толгойлогчийн хамтарснаас үүдэж, улмаар 36 аймгийг нэгтгэсэн нь билээ. Дараа нь Ордос, Цахар нэгдэн цаашилаад Солонгосын нутгийг эзлэв. Ингэснээр зүүн тийш Ялу мөрөн, баруун талаараа Хэлан (jia lan shang ) уулын зах хүртэлх уул ус, газар нутаг бүгдээрээ түүний захиргаанд багтах болов. Дотоод нутгийн гэмтэн ялтнууд Манжтай нийлснээр тэдэнд хүчин зүтгэх хүмүүсийн тоо үнэхээр олон болжээ. Тэд жил бүр хил даван халдаж, газар газраар довтлон цөмөрсөөр, бидний есөн хилийн цайз тайван бус байна. Эдүгээ Манжид дагаар ороогүй нь зөвхөн Халх болон Түмэдийн үр хойчис үлдсэн болой. Мөн Мин улс худалдаанаас ашиг хүртдэг тул Манжтай нэгдээгүй байна. Халх нь Манжтай тэмцэх хүчтэй боловч Манж нар халхчуудыг үл тооно. Харин Түмэдийн хувьд өмнө нь Алтан хан 40 жилийн турш Мин улсад хүлцэнгүй тайван хандсан. Иймд бидний уламжлалт харилцаа хадгалагдсанаар Түмэдүүд Хөх хотын нутгийг өөрийн болгомуй. Халх хэзээд Манжтай эвсэхгүй гэж итгэх боломжгүй ба эргэж буцах өөрчлөлтийг мэдэх аргагүй. Мөн Түмэд хэзээ ч бидний эсрэг аюул болохгүй гэж хэлж чадахгүй. Учир нь энэ ч бас нүд ирмэхийн зуур тааварлах аргагүй хэрэг мөн. Өнгөрсөн өвөл Түмэдийн хоёр аймаг мөнгө зээлж, сайн дураараа хил хамгаалахаар болов. Зүрчидийн дундах мэдээллийг судлаад миний өмнө албан бичгээр явуул гэсэн боловч ямар нэг тодорхой үйл явдал ажиглагдасангүй. Зөвхөн тэд хэрмийн гадна талд зогсож, хагас жил орчим хөдөлсөнгүй. Тэд өөрсдийгөө хүндэтгэлтэйгээр дагаж буйгаа хэлсэн. Иймд би үнэндээ тэд нараас татгалзах шалтгаан алга. Харин тэд бутарсан халх адууг өөрийн болгож, ажил амьдралаа залгуулдаг. Ерөнхийдөө нүүдэлчдийн хулгайлах явдал хэвийн үзэгдэл болмой. Ойр орчмын чимээ сонссон халхчууд аль хэдийн ухаарч Түмэдийн зуучлалыг авахгүйгээр шууд өөрсдөө ирж арилжаа хийхийг хүсмүй. Харин Түмэд нь Халхаас ойрхон байгаа тул ямар нэгэн заль мэх гарч мэдэх тул хязгаар тавих хэрэгтэй. Бас тэдэнд наймааны эрх өгвөл их омог зантай болох ажээ. Хил хамгаалалтын захирагчдад тушаал хүргүүлсэн ину: Цаашид Халхчууд зээлд адуу тууж ирвэл шууд худалдаа хийлгэ, Түмэдүүд ирвэл тэднийг боомтын эрхээр нэвтрэх хуулийг дагамуй. Тэднийг гарын алга мэт жижиг нохой мэт захиран ашиглаж, хагас өлсгөлөн, хагас цатгалан байлгаж, боомтод удаан саатуулж дасгах. Би өөрийн эрх мэдэл доор нууцаар ажиглаж, гаднаа энэрэнгүй найрсаг харилцааг үзүүлж, дотооддоо хатуу чангаар хянана. Ингэснээр Түмэдийг нэг арга барилаар цагдаж болмуй.

Баруун халхын иргэд хорь, гучин мянгаар ирэхэд, тэдний эрэлхэг догшин зориг нь Зүрчидээс илүү. Өөрсдийн газрууд нь маш хүйтэн, зан чанар эгэл даруухан боловч бүдүүлэг. Тэд Мин улсаас цай, мөнгө хүсэх төдий агаад өөр санал бодол ер байхгүй. Нэг морь худалдаалбал хэдэн арван лан мөнгө авч, түүнийхээ хагасаар цай, бөс даавуугаар сольдог. Энэ зоос буцаад манай улс руу орж ирэх нь үнэхээр ашигтай болой. Саяхнаас сонсоход зүрчидүүд халхчуудын адууны арилжаанд нэлээд дургүйцэн хилэнгэж, саатуулахыг оролдмуй. Би адууны худалдаанд бага зэрэг өршөөл итгэл үзүүлж, үнэ хаялцаанд хохирол бүү учруул, хугацаанаас болж алдагдал бүү үүсгэ хэмээмуй. Миний өмнөх өргөн мэдүүлсэн бичигт өгүүлсэн ёсоор: Түмэд, Халхыг түшиглэж, халхчуудыг Зүрчидийн эсрэг ашиглах нь нууц арга ухааны гол асуудал энд хэрэгжиж баймуй. Зүрчид ойр бол халхчууд хол. Холтой нь эв найрамдал тогтоож,

*ойр байгаатай нь дайсагнаж буй магад. Энэ нэг аргаар халхчуудыг удирдах буй за. Ерөнхийд нь хэлбэл, Түмэд болон Халх нарын дунд хагарал байх ёстой. Харин Халх ба Зүрчидтэй харилцахдаа тархай бутархай байдлыг хадгалж, эв нэгдэл бүү үүсгэмүй. Бас Түмэдийг хөдөлгөж Зүрчидийн сул байдлыг мэдэж тэд нарыг Зүрчидийн эсрэг чиглүүлж болно. Түмэд болон Халх нарыг салгаж, нэгтгэхгүй байх ба тэднийг удирдан жолоодох эрх миний гарт байна. Мөн Түмэд нартай холбоо тогтоох нь зөвхөн стратегийн эхлэл. Цаашидын гүн гүнзгий зорилт нь Халхчуудаар Зүрчидийг дарж авах. Халх ба Зүрчид нарыг өөр хооронд нь хагаралдуулж тулалдуулбал ялалтын давуу тал бидний талд ормуу. Цаашид худалдааны зах нээхдээ Шаху, Жанчхүү боомт гэсэн дараалал эсвэл хамтад нэгэн зэрэг нээвэл харь хүмүүсийн ая тухад нийцнэ. Гэхдээ тухайн өдөр хаанаас зарлиг гуйх нь саад тотгор гарч болзошгүй ажээ. Өчүүхэн хүн би гуйваас, Их эзэн хаан та цэргийн яаманд зарлиг буулгаж, урьдчилан тунгаан бодмуу. Бид болон бусад түшимэдэд мөрдөн хэрэгжүүлэх тушаал буулгамуй<sup>31</sup>.*

Илтгэлд, Мин улс 1636 оны (Чунжэний 9 дүгээр он) намар, өвлийн улиралд халхчууд Шаньси мужийн Шаху боомтод ирж 20,000 адуу арилжсан байна. Дээр дурдсан “Зүүн халх хүн ам цөөн, сул дорой, нутаг дэвсгэрээр Зүрчидтэй зэрэгцэн оршдог бол Баруун халх хүчирхэг, хүн олонтой, Зүрчидээс хол тул эсэргүүцэх чадвартай” хэмээсэн нь Халхын зүүн гар Манжийг түшдэг бол Баруун гар нь Манжаас алс хол, тэдний эсрэг зогсож чадна гэсэн санаа ажээ. Лу Сяншэн мөн халхчуудыг Мин улстай шууд худалдаа хийх чиг хандлагатайг анзаарсан бөгөөд халхчууд түмэдүүдэд зуучлал хийсний төлбөр өгч мөлжүүлэхийг хүсэхгүй байгааг тэр ойлгосон. Бас Түмэдийг аль хэдийнэ Чин улсын захиргаанд орсон байсныг мэдээгүй байна. Түүний зэрэгцээ Лу Сяншэн халхчуудыг Мин улстай адуу худалдахыг Чин улс хязгаарлаж байсныг мэдсэн. Чин улсын энэ бодлого нь халхчуудын дургүйцлийг төрүүлжээ. Лу Сяншэн нь цаашид адуу худалдааар ирсэн Цэцэн ханы хүмүүсийг Жанчхүү боомт руу шууд оруулж, харин Түмэдүүдийг гагцхүү худалдааны эрхээр нэвтрүүлэхээр санал болгожээ. Энэ хэргийг Мин улсын засгаас хүлээн зөвшөөрч баталгаажуулснаар Халхчууд Жанчхүүгийн боомтод шууд худалдаа хийх болж бас Түмэдүүдийн зуучилж мөлжих оролдлогыг зогсоосон байна. Чунжэний 10 дугаар оны 7-р сард (1637 он) Баруун халхын худалдааны бүлэг Сюаньфү, Жанчхүү боомтод хүрч ирсэн бөгөөд энэ тухай Ян Сычаны өргөсөн бичигт дурджээ.

*Тус түшимэл Сычаны ажигласнаар Халхын аймаг нь уулаасаа зүүн, баруун гарт хуваагддаг агаад хоёр тал аль аль нь морь сайн үйлдвэрлэдэг.Тэдэнд хан цай болон даавууг нийлүүлж байгаа гэж би хэд хэдэн удаа хаанд албан бичгээр мэдэгдсэн... Энэ оны илүү 4-р сарын 21-ний хааны зарлигийг хүлээн авсан. Адууны худалдаанд Халх, Түмэдийн гэж ялгахгүйгээр ирсэн адууг шууд худалдаж авах арга хэмжээ авч, зүүн баруун хэсэгт хувааж хянамуу. Тухайн захиргааны түшимэлүүд нөхцөл*

<sup>31</sup> 兵部尚书杨等谨题为再陈卜哈情形以策安边机榷事》，崇祯十年闰四月十八日，兵部题 《宣大总督卢象昇题》行稿，《明清史料》甲编，第九本，第 875-877 页。

*байдлыг харгалзан ухаалаг, уян хатан арга хэмжээ авч, хааны зарлигийг албан ёсоор баталсан ба биелүүлэн даган мөрдөж, тэмдэглэл хөтлөв.*

*Эдүгээ Халхын зүүн, баруун гарын аймгууд зэрэгцэн Сюаньфү, Датун хотуудад ирвэл хоёр зах зэрэг нээгдэн үнэхээр Мин улсад их ашигтай. Өмнө миний өгүүлсэн саналтай нийцэхгүй мэт боловч яг одоо намрын хил хамгаалалтын байдал урьдчилан таамаглах аргагүй байна. Хэдийгээр Манжууд өдөөн хатгалга хийх мэдээлэл байхгүй ч хэрхэвч хамгаалалтыг сулруулж болохгүй, хэзээд дайны бэлэн байдлыг сахьмуй. Үүнээс гадна өмнө нь Ляодун, Минюний харьяат иргэдээс ирүүлсэн мэдээ ба Сюаньфүд томилогдон буцаж ирсэн ахлагч Жуо Тянь И (卓天意) -ний мэдэгдсэнээр: Зүүн этгээдээс Лансун гэх ч лам ижил өдөр хөдөлж (ахлагч Жуо Тянь И-тэй нэг өдөр ирсэн) 1500-1600 адуу тууж ирсэн. Датунаас ирсэн илтгэлээс харахад Нансун лам мөн буюу. Тухайн этгээд урьд мянган адуу боомтод хөөж авчирсан хэрэг байгаа тул иймд зайлшгүй их анхаарч, нухацтай тунгааж, сэрэмжтэй баймуй. Дорд би эргэцүүлэн бодоход Датунд зах нээгээд удаж буй. Нансун лам бол Манж уу эсвэл Баруун халх уу гэдгийг мэдэхэд бэрх биш. Урьд баруун харуулын мэдэгдсэнээр, халхын хүмүүс Шар шаврын хөндийд (huang ni wa) адуу тууж ирээд бараагаар солилцоо хийжээ. Энэ нь өнгөрсөн үйл явдал болой. Тус өдөр Жуо Тянь И-тай хамтаар Датуны худалдааны хаалганд хүрч ирэв. Шар шаврын хөндий гэдэг газартай холбоогүй. Харин Датунаас ирсэн илтгэлд Зүүн халхчууд Баянтүмэн хот руу явж, Баруун Датунд ирсэн гэх нь магадгүй үнэнд ойр байж мэднэ. Тийм бол адуу хаалганд ирэх үед яаралтай худалдан авах нь зохистой. Одоо хот тосгон бүрд морьд нэн шаардлагатай байгаа ба худалдаж авахад хэцүү байна. Иймээс хааны ордны алба морь худалдан авахаа түр зогсоож, тус тосгонд томилогдсон түшмэлүүдэд өөр өөр газруудаар худалдахыг зөвшөөрч, таван өдрийн дотор бүгдийг нь худалдан авч дуусгахын зааварчилмуй. Чунжэний 10 дугаар он (1637) 7-р сарын 22-нд<sup>32</sup>.*

Зүүн халх нь Баянтүмэн хотод хүрч даруйхан Жанчхүүгийн боомтод арилжаа хийх бол Баруун халх Датунд ирж тэр дороо Шаху боомтод худалдаа хийхийг хүсэж байгааг Мин улсын төлөөлөгч олж мэджээ. Халх монголчуудын хувьд ямар ч нөхцөлийг үл хамааран шууд худалдаа хийх эсвэл Түмэдийн зуучлалаар дамжуулан худалдаа хийхийг зорьсон бол Мин улс бүх адууг идэвхтэй худалдан авч байжээ. Цэргийн яамны “Адуу худалдаа амжилттай дууссан болон хил хаах өдрийг хүндэтгэн мэдүүлэх тухай” гэсэн баримт бичгийн мэдүүлэгт:

*Чан Сюань замыг хариуцагч тайган Жэн Лянфү (zheng liang fu)-ийн мэдүүлэг. Чунжэний 10 дугаар он, 7-р сарын 22-нд. Би Жанчхүүгийн боомтод ирж зах нээж адуу худалдаж эхэлсэн бөгөөд 8-р сарын эхний өдөр гэхэд адууны худалдаа бүрэн дууссан. Дараа өдөр буюу 8-р сарын 2-нд би болон бусад түшмэлүүд боомтын хаалга хаах албан бичгийг үзүүлэхээр халхын арав гаруй тэргүүлэгчдийг дуудаж авчран танилцуулсан. Мин улсын хаан төрийн ордны уян зөөлөн холын бодлого, ёс суртахуунтай чанарыг зарлаж, бүгд ариун бурхны өмнө хутгаа нийлүүлэн андгай*

<sup>32</sup> 杨嗣昌：《哈马东西俱到疏》，载《杨文弱先生文集》卷16，《四库禁毁书丛刊》，集部第69册，第275-276页。

өргөж, хоёр тал адууны захыг хэзээд нээж хоорондын үр ашгийг баталгаатай болгомуй<sup>33</sup> хэмээн тангарагласан бөлгөө.

Өмнө дурдсан Цэцэн хан аймгийн худалдаачид долоон сарын эцэст Жанчхүү дахь худалдаагаа дуусгасан байна. 8-р сарын 7-нд Баруун халхын худалдаачид (Халх баруун гарын Засагт хан аймаг) мөн Шаху боомтод ирж худалдаа хийсэн хэмээн цэргийн яамны баримт бичигт дурдсан байна.

*Баруун гарын цэргийн түр орлон гүйцэтгэгч Кан Жэньбан (kang zhen bang) өргөсөн мэдүүлэг болон Шаху цайзын хамгаалагч офицер Гао Луаны бичигт дурдсанаар: 1637 оны (Чуньжэний хааны 10 дугаар он) 8-р сард Баруун халхын лам, хувраг нар мянга гаруй адуу тууж хилд ирж, ийнхүү өгүүлрүүн: “Би уулын өмнөдөөс ирлээ: мэдвээс Манжийн удирдагч бидэнтэй найрамдаж энхийн хэлэлцээ хийхээр олон удаа элч илгээсэн буюу адуу арилжиж наймаа хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Харин Баруун халхын ханы хүү, ноёд бид эс зөвшөөрөв. Тэд дахин морь, тэмээ нэхэв. Бас л манай хан хөвгүүн өгөөгүй. Одоо Манжийн ноён 3-4 мянга орчим нэгэн салаа дивиз цэрэг томилж, хойд уулын ар талаас баруун зүгт чиглүүлэн явуулав. Ам дамжсан яриагаар тэд манай нутагт адуу худалдахаар ирж яваа буй. Гэвч үнэндээ нууцаар дээрэм хулгай хийж, алж устгах гэж ирнэ. Иймд бид хэдийнээ сэргийлэн болгоомжилж байна<sup>34</sup>.*

1637 оны (Дээд эрдэмт хааны 2 дугаар он. Чуньжэн хааны аравдугаар он) 8-р сард Сюаньфү хотод дахин Баруун халхын хүмүүс адуу худалдахаар ирсэн тухай мэдээ ирүүлжээ.

*Энэ сарын гуравны өдөр Жанчхүүгийн цайзын харуулын дарга Жоу Хунью (zhou hong you)-ийн өргөн барьсан бичигт тулгуурлавал: Баруун халхын Түшээт хан аймгийн харьяат мэргэн Лансун лам (没勒良郎速), Эрдэнэхан (以儿邓哈) тэргүүтэй харь нутгийн монголчууд нийт 500 гаруй хүн, 1000 гаруй адуу худалдахаар иржээ. Мөн харь ноёны иргэд өргөдөлдөө бидний их хүрээ араас ирж буй. Магадгүй энэ сарын 5-наас 6-ны өдөрт хүрч ирэх болой хэмээв. Тэдний дотор нэгэн харь хүн өмнө нь хилийн гарц дээр томилогдон ажиллаж байсан ба ахлагч Жуо Тянь И таньдаг ажээ. Үүнээс үндэслэвэл харь иргэдийн адуу худалдаа энэ хэрэг залгамж холбоотой бололтой. Дэлгэрэнгүй мэдүүлгийг дээд албан тушаалтанд өргөж, улмаар өөрийн түшмэлд дамжуулан уламжилж мэдүүлэв. Түшмэл би өмнөх удаагийн Зүүн халхын адууны худалдааг амжилттай дуусгаж, орон нутгийн аюулгүй байдлыг хангаж, одоо бүртгэл хийж тайлангаа өргөхөөр бэлдэж байтал эдүгээ дахин халхын Баруун гарын 500 хүн, 1000 гаруй адуу дагуулж хилд ирж худалдаа хийх хүсэлт гаргав... Зүүн халхын Түшээт хан аймгийн харьяат Цэцэн лам зэрэг 500 гаруй халх иргэд бидэнд 1000 орчим адуу байгаа ба урагш Жанчхүү боомтод орж худалдаа хиймүй хэмээн мэдээлэв. Манай албан газрын ажигласнаар халхчууд эхний адууны*

<sup>33</sup> 《兵部题为市马已竣恭报闭关日期事》，崇祯十年八月，《明朝档案总汇》，第 25 册，第一九八零件。

<sup>34</sup> 《兵部尚书臣杨等谨题为塘报事》，崇祯十年八月十一日，《明朝档案总汇》，第 25 册，第一九六零件。

худалдаагаа хурдан дуусаж, даруйхан цэргийн хуарангаа татан буулгаж буцав. Бас тогтуун байж ямар нэгэн үймэн үүсгээгүй гэж хэлж болно. Тэгээд худалдааг түр хааснаас хойш удалгүй тус сарын 3-ны өдрийн мэдээнд Баруун халхын 500 орчим хүн, 1000 гаруй адууг хилд тууж хүргэсэн ба 5-ны өдөр ирсэн бичигт дахин Зүүн халхын 500 гаруй хүн, 1000 гаруй адуу боомтод хөтөлж иржээ. Одоо Зүүн ба Баруун халхыг ямар нэгэн байдлаар ялган таньж тодорхой болгох шаардлагатай. Үүнийг тухайн хилийн хяналт хамгаалалтын түшмэлүүд үнэн зөвөөр шалгах ёстой. Би зарлиг буулгаж хамгийн түрүүнд ирснийг нь эхэлж худалдаанд оролцуулсан. Эмх замбараагүй байдал үүсгэхээс сэргийлэх үүднээс нэгэн зэрэг дайран тэмцэл, үймээн самуун гаргахыг хориглов. Мөн хүчтэй дайсангаар тулгарахад юуны урьд цэргийн хүчийг чангатгаж бэлтгэлтэй байхыг тушаасан. Цэргийн ерөнхий командлагч Ян Гуйжутангийн тайлангаар Зүүн, Баруун халхын нэришл нь үсгээр ялгаатай ба эдгээр нь Түшээт ханы харьяатад хамаарах бөлгөө. Ер нь харийн хүмүүс адуугаа хилд авчирч худалдаалах нь хэвийн үзэгдэл. Тэд өмнө болон дараагийн ээлж гэж цувран ирдэг бөлгөө. Чуньжэн хааны аравдугаар он 8-р сар<sup>35</sup>.

Мин улсын цэргийн ерөнхий жанжин Ян Гуйжу(Yang Guo Zhu) -ийн цуглуулсан мэдээ ба өмнөх айлтгалуудад тэмдэглэснээр эдгээр Баруун, Зүүн халх хүмүүс нь бүгд Түшээт хан аймгийн харьяатууд гэж тодорхойлжээ(Түшээт ханы хөвгүүд гэдэг нь Түшээт ханы харьяат). Түшээт хан аймгаас адуу худалдахаар Жанчхүү боомтод хүмүүсийг илгээжээ. Халхчууд хоёр бүлэгт хуваагдан ар араасаа дараалан ирсэн ба эхний хэсгийг мэргэн Лансун лам магнайлсан бол хоёр дахь хэсгийг Цэцэн лам удирдаж явжээ.

Цэргийн яамнаас өршөөл хүндэтгэлтэйгээр өргөн мэдүүлсэн “Баруун халхын худалдаа дуусаж, уул нутагтаа буцсан тухай” бичигт дурдсан нь:

Энэ оны 8-р сарын 24-ний өдөр хилийн харуул хамгаалалтын жанжин Жоу Хунью дахин бичиг өргөв. Дараалан ирсэн халх иргэдийн ахлагч мэргэн Лансун лам болон Эрдэнэхан нар 8-р сарын 15-нд хутга нийлүүлэн андгай тангараг үйлдэж, дараа нь хэд хоног үргэлжлүүлэн адуугаа худалдаж дуусаад нутаг буцахыг айлтган мэдүүлэв. Үүнээс үзэхэд түшмэл миний бие ажиглахад Жанчхүү боомтын худалдаа хоёр удаа нээгдсэнээр цэргийн суурин бүр дайнд хэрэглэх адууг бүрэн хангаж чадсан. Харин худалдааны боомтод чанд сахилга бат тогтоосноор ямар ч түгшүүр, үймээн гараагүй байна. Энэ нь ашиг тустай бас хор хөнөөлгүй болой. Гүнзгий тооцоолон боддог хүмүүс захыг нээж хаах гэсэн хоёр үзэлд эргэлзэж тэр ч бүү хэл Жанчхүүгийн адууны худалдааг Датунтай нэгтгэх санал гаргав. Харин мунхаг миний бодлоор ийм саналыг огтхон ч үл зөвшөөрмүй. Өмнөх жилүүдэд түшмэл би Датун хотод хяналт тавьж, тухайн үед морин цэрэг цөөн сул дорой тул Баянтүмэн цайзад нэмэлт хүч өгч чадаагүй билээ. Дараа нь Шаху боомтод адууны арилжаа нээгдсэнээр албан хаагч, худалдаачидтай уулзаж, мөнгө, олон төрлийн барааг цэргийн хүч ашиглалгүйгээр авсан. Түүнчлэн орон нутгийн захиргаа ч худалдааны хишиг хүртсэн ба нэг жилийн дотор өмнөх хилийн бэхлэлтийг шинэчилж, ядарсан цэргүүдийг тэнхрүүлж чадсанаас үзэхэд худалдааг нээх нь хохиролтой гэж хэлж болохгүй билээ. Одоогоор Баянтүмэн

<sup>35</sup> 《兵部题为夷情事》，崇祯十年八月，《明朝档案总汇》，第24册，第一九五七件。

*хотод бэхжүүлэлт сул дорой байгаа болохоор адууны зах зээлээс ашиг орлого, эд баялгаа олох нь зүйтэй. Харин хил хааж өөрийн давуу талыг алдах гэж үү? Зарим хүмүүс Зүрчидүүдийг урьдчилан тааварлашгүй зальтай, магадгүй Халх, Түмэдийг ашиглаж санаагаа хэрэгжүүлэн гэнэт нэвтрэн орж ирнэ хэмээн үзэж, боомтоо хааж болгоомжтой байхыг илүүд үзгүй. Зүрчидүүд олон жил биднийг заналхийлж байгаа боловч хэзээ ч худалдааны хаалгаар нэвтэрч байсангүй билээ. Хэрэв бид урьдчилан бэлтгэхгүй бол тэд бүх хаалгаар нууцаар орж ирэх болно. Чуньжэн хааны 10 дугаар он. 9-р сарын 8-нд<sup>36</sup>.*

Мин улс дайнд бэлдэх шаардлагатай тул Халхын адууг идэвхтэй худалдаж авах төдийгүй тэднийг хожуу Алтан улсын эсрэг ашиглаж, хүчийг нь сааруулахыг оролдож байв<sup>37</sup>. Сюаньфүгийн түшмэд Жанчхүү боомтын адууны худалдааны захыг Датунд нэгтгэхийг эсэргүүцжээ. Учир нь тус газар адуу худалдааны захыг нээлттэй байлгах нь хотын эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэх ашиг тустай байсан юм. Халхчууд Мин улстай шууд худалдаа хийх болсноор Сюаньфү дахь Жанчхүүд адуу худалдааны захад арилжаа хийхийг зөвшөөрөв. Иймд Халхын зүүн гар Жанчхүү рүү шилжиж, харин Баруун гар нь хуучин ёсоор Шахуд тус тус худалдаа хийх болжээ. Халхчууд нэг талаар Мин улстай худалдаа хийж байсан бол нөгөө талаар Өмнөд Монголыг эзэлсэн Чин улсад элч илгээж дипломат харилцаагаар сөргөлдөн тэмцэж байв. Дээд эрдэмт хааны хоёрдугаар оны (1637 он) 8-р сард Цэцэн хан болон Түшээт хан Чин улсад элч зарж, Халхын гурван аймаг Чин улсын засгаас 5-р далай ламыг урьсныг дэмжиж буйгаа илэрхийлээд танай улстай хамтран элч илгээж урьж залбал зохистой хэмээн үзжээ<sup>38</sup>.

## ГУРАВ

Чин улс өөрийн эдийн засгийн ашиг сонирхлоо баталгаажуулах болон Халхыг дагаар оруулахын тулд тэднийг Мин улстай харилцан худалдаагаа зогсоохыг хэд хэдэн удаа шаардаж, анхааруулсан. Гэвч Халхчууд уг сануулгыг үл тоомсорлосон ба үүний улмаас Чин улс нь Мин улсын худалдааг зогсоохын тулд цэргийн хүч хэрэглэх арга хэмжээ авчээ. Дээд эрдэмт хааны гуравдугаар он 1-р сард. Халхын Засагт хан аймаг иргэдээ Хөх хотын ойролцоо байршуулж, Мин улстай харилцан худалдаа хийхийг зорьж байв. Энэ мэдээг сонссон Хунтайж өөрийн биеэр цэрэг авч хөдлөв. Иймд Засагт хан аймгийн хүмүүс аргагүй хүчинд автан буцжээ<sup>39</sup>.

<sup>36</sup> 《兵部为恭报西哈市竣回巢事》，崇祯十年九月初八日，《明朝档案总汇》，第 26 册，第一九九九件。

<sup>37</sup> 前引 《兵部尚书杨等谨题为再陈卜哈情形以策安边机榷事》；又见 《覆宣督驭彝当求远略疏》，崇祯十年十一月十九日，《杨文弱先生文集》卷 20，《四库禁毁书丛刊》集部第 69 册，第 317-318 页。

<sup>38</sup> 《清太宗实录》卷 38，崇德二年八月辛丑、庚戌。

<sup>39</sup> 《清太宗实录》卷 40，崇德三年正月庚辰；二月丁酉、癸丑。《兵部为飞报夷情事》，崇祯

2-р сард Чин улсын цэрэг Сюаньфүгийн хилийн гадна ирэхэд, Засагт хан аймгийн хүмүүс аль хэдийнээ ухарч зайлсан болохыг мэдэв. Хунтайж өөрийн итгэлт хүн Шонхор баатар, Лувсан нарыг томилж Мин улсын Сюаньфүгийн түшмэлд захидал хүргүүлжээ. Тэр захидалдаа ийн өгүүлрүүн.

*Чин улсын энэрэнгүй хүнлэг ариун хаан Мин улсын Сюаньфүгийн төлөөлөгчдөд захидал илгээв. Бичин жил (Тэнгэр цэцэний зургаадугаар он). Би их цэрэг удирдан Цахарын эсрэг хөдлөв. Гэвч Цахарууд энэ мэдээг сонсоод зугтаасан ба одоо Хөх хот болон тэдний ард түмэн бүгд миний харьяат болов. Тэр үед Сюаньфүгийн түшмэлүүдэд хандан ийнхүү хэлэв. Танай Сюаньфү, Датуну хүмүүс миний өстөн биш. Харин Ляодун хилийн ноёдууд намайг хэтэрхий их доромжилсон учраас би тэднийг байлдан дагуулав. Өнөөдөр та нар надтай найрсаг харилцаа тогтоож, харилцан худалдаа хийхээр болсон. Тиймээс жил тутам Цахарт олгодог байсан өргөл барьц бүгдийг манай улсад өгөх ёстой. Чиний хэлсэнчлэн Цахар зугтаасан боловч тэдний тэргүүлэгч (хунтайж) амьд хэвээр байгаа. Хэрэв дахин ирж жил тутмын өргөл хийгээд худалдааны эрхийг шаардвал яаж хариу барих вэ?. Хэрэв тэр амьд байгаа юм бол жил бүрийн худалдааны эрхийг танай улсад түүнд өгөх нь зохисгүй бус уу?. Хэдий чи тэдэнтэй тохиролцсон боловч бүх талаараа нийцсэнгүй. Гэхдээ манай улстай эвлэрч худалдааг нээж тэнгэр газарт мөргөж үнэнч байхаа тангарагласан тул бидний их цэрэг хилд орохгүйгээр буцав. Хожим би энэ тангаргийг дагаж нэг жилд хоёр ч удаа элч зарж захидал илгээсэн боловч эцэст нь тангаргаа эвдэж, хариу хэлсэнгүй. Тиймээс би модон нохой жил (Тэнгэр цэцэний наймдугаар он - 1634 он) цэрэг хөдөлгөсөн билээ. Өнөөдөр дэлхий дээрх бүх Монголын нутаг миний эзэмшилд багтаж, тэр ч байтугай Солонгос улс миний вассал албат болжээ. Цахарын хаан миний сүр хүчнээс эмээн алс газар зугтааж, өөрөө нас барж улс нь мөхсөнөөр би түүний эхнэр хүүхэд, ард олон бүгдийг нэгтгэж авсан билээ. Чи урьд нь ядуу дорой үгээр шалтаг гаргаж Цахарын хаан амьд байгаа гэж хэлдэг байсан. Одоо чи өөр ямар үг хэлж бултах вэ?. Тэр умардын Халх монголчууд та нартай андгай тангараг өргөж, найрамдах сэтгэл байсан уу?. Гэтэл та нар тэдэнтэй харилцаж жил тутамд худалдааны захаа нээж байна. Харин андгайлж холбоотон болсон улсдаа жил бүрийн алба ба худалдааны захыг нээхгүй байна. Энэ юу гэсэн үг вэ?. Би одоо өөрийн биеэр их цэргээ удирдаж, Буян-Ахай бэлчээрийн газар буудаллаж хүлээнэ. Хэрэв чи гэмшиж алдаагаа засаад, жил бүр надад өргөл өгч, захаа нээж, харилцан худалдаа хийвэл бид Сюаньфү, Датунд цэрэг оруулахгүй төдийгүй Ляодуны довтолгоог зогсооно. Иймээс эсэргүү үйлдэл гаргавал дайлаар мордоно. Харин найрамдвал худалдаа хийнэ. Энэ бол эртний уламжлал юм. Хэрэв чи цаг хугацааг зөв тунгаан бодохгүй, миний тушаалыг эсэргүүцвэл би Солонгос, Монголын их цэрэгт тушаал өгч хэд хэдэн замаар хуваан довтолгож, тариалангийн талбайг чинь устгана. Ингэснээр чи харамссан ч дараа нь оройтсон байх болно<sup>40</sup>. Ийнхүү үнэнийг шулуухан мэдэгдэж байна. Иймд чи сайтар тунгаан бодож даруй хариугаа илгээгтүн.*

Тэнгэр цэцэний зургаадугаар онд Хожуу Алтан улс Цахарт цэрэглэн хөдлөх

十一年正月二十七日，《明朝档案总汇》，第28册，第二一四一件。

<sup>40</sup> 清太宗实录》卷40，崇德三年二月壬戌。

үедээ Сюаньфүд элч илгээж, жил бүрийн худалдааны эрхийг шаардав. Урьд Сюаньфүгийн цэргийн захирагч Шэнь Чи (shen qi)-тэй харилцан тангараг өргөж, найрамдлын гэрээ байгуулан худалдаа хийхээр болжээ<sup>41</sup>. Чин улсын Хунтайж энэ үед Мин улсын Сюаньфү цайзаас жил бүр өргөл авч арилжааны захыг нээхийг шаардаж, Цахарын Лигдэн хааныг төлөөлж Монголын бүс нутаг, Мин улсын хоорондын худалдааг хянахыг зорьж байлаа. Сюаньфү, Датун цэргийн ерөнхий захирагч Лу Сяншэн яаралтай илтгэв. Үүнийг цэргийн яамны сайд Ян сычан өөрийн санал оруулж хавсарган өргөн барив.

*Боол би Сюаньфү, Датун тайлан болон ерөнхий байцаагч, түшмэдийн өргөдлүүдийг хүлээн авч тэдгээрт хариу бичиг бэлтгэж байтал энэ сарын 9-ны 3-5 цагийн үед ерөнхий захирагч Лу Сяншэн өөрийн гараар бичсэн 7 дугаартай тагнуулын мэдээг хүлээн авав. Энэ илтгэл нь манай яамаар дамжаад хааны сонорт хүрэх ёстой. Энэ хэрэг маш чухал нууц тул би хэн нэгнээр бичүүлж хуулбар гаргуулах зориг байсангүй. Эх хувийг битүүмжилж хааны мэлмийгээр үзүүлэхээр өргөн барьлаа. Хааны ариун шийдвэрийг нууцаар хүлээнэ. Та юу зөв, юу бурууг мэдэж хариу өгмүй. Ийм учраас энэ баримтыг бүрэн бүрдүүлж хүндэтгэлтэйгээр өргөн мэдүүлэв. Зарлигийг толгой бөхийлгөн хүлээнэ.*

*Чуньжэний аравдугаар он (1637) 3-р сарын 9-ны өдөр. Цэргийн яам харь хүмүүсийн хэрэг явдлын талаар нууцаар өгсөн илтгэл. Тус яамны бичигт энэ зэргээс шалтгаална... хэмээн тэмдэглэжээ. Чуньжэн хааны арван нэгдүгээр он(1638), 3-р сарын 9-ны өдөр... Мөн яамны сайд Ян Жү-ийн бичигт танилцуулсан 11-р сарын 10-ны өдөр, үдшийн 21 цагт ариун хааны зарлигийг хүлээн авсан. Тагнуулын мэдээгээр зүүн зүгийн Манжууд мөн тул захыг ямар нэрээр, ямар үндэслэлээр нээх билээ? Хэрэв Цахарын харьяанд байсан хуучин харьяатууд Манж нартай нийлэн урвал яах вэ? Үүний оронд тэд нараар Манжийг устгуулж өөрийн үнэнчээ батлан харуулбал худалдааны эрх болон шагналыг олгож болмой. Иймд тус даргад нэг арга зохион байгуулж нууцаар хэрэгжүүлэхийг тушаав. Мөн цэргээ цуглуулан нягт бэлэн байдалд оруулах, хуурамч үйлдэл гаргахгүй, мөн улсад хор учруулахгүй байх хэрэгтэй. Танай яам яаралтай тушаалыг хэрэгжүүл хэмээв. Эзэн хааны зааврыг соёрхон тогтоож, хүндэтгэлтэйгээр даган биелүүл. Бичгийг яаманд хүргүүлж, зохицуулан хэрэгжүүлэхээр бэлтгэнэ. Иймээс ерөнхий даргад зөвлөмж илгээж, хааны зааврыг дотоод хэрэг, журамд нийцүүлэн гүйцэтгэ. Чуньжэний арван нэгдүгээр он(1638), 3-р сарын 1-нд<sup>42</sup>.*

Чуньжэн хаан Чин улстай худалдаа хийхийг хүсээгүй. Харин “Цахар аймаг болон өмнө нь худалдаа хийж байсан нүүдэлчид” харилцан худалдааг зөвшөөрөв. Ян Сычаныг нууцаар хэрэгжүүлэх арга зам олохыг тушаав<sup>43</sup>. Чуньжэний Үнэн

<sup>41</sup> 《清太宗实录》卷 12, 天聪六年六月己卯、戊子、甲午

<sup>42</sup> 《兵部奏为密奏夷情事》，崇祯十一年三月十一日，《明朝档案总汇》，第 29 册，第二一九二件。

<sup>43</sup> 杨嗣昌召对笔记，见《杨文弱先生文集》卷 47，《四库禁毁书丛刊》集部第 69 册，第 702 页。

тэмдэглэл, Ууланд сууж сонссон тэмдэглэл зэрэг сурвалжид бичсэнээр Лу Сяншэн хаанд өргөсөн тайландаа зах зээлийн тухай ярьж болохоос шагналын тухай ярьж үл болно гэж үзжээ. Ча бү харийнхан буюу Харчин аймагтай Жанчхүүд харилцан худалдаа хийсэн байна<sup>44</sup>. Бодит байдал дээр Мин улс Чин улстай Харчин аймгийн нэрийн доор Сюаньфүд харилцан худалдаа хийхээ болжээ.

Дээд эрдэмт хааны гуравдугаар оны (1639) 3-р сард, Шонхор баатар Лувсан нар Сюаньфү буцахдаа өргөсөн бодрол бичигтээ: Халхын Цэцэн ханы элч нар арилжаа хийхээр Мин улс руу явж байх замд бидэнтэй тааралдав. Тэднээс 140 адуу, 40 тэмээг олзлов. Харин тэнд байсан монгол хүмүүст замын хүнс болгон хонь өгч буцаасан ба хоёр хятад хүнийг олзлон авчирсан<sup>45</sup> хэмээн өгүүлжээ. 7-р сард Чин улсын төр Мин улсын талаас тодорхой хариу авсны дараа тавнан Даянч, Харчин аймгийн Билаш, Лашсамбуу нарыг хамтад нь Жанчхүүд илгээж Мин улсын хилийн боомтын түшмэлүүдтэй жил бүрийн худалдааны өргөл барьцны тухай ярилцаж, харчин бэйлүүдэд урьдын адил ижилхэн хэмжээний мөнгө өгөх болон боомт нээх, хаах, харилцан худалдааны асуудлыг хэлэлцэв<sup>46</sup>. Тавнан Даянч зэрэг бусад төлөөлөгчид Мин улсын Сюаньфүгийн түшмэдтэй хурдан хугацаанд арилжааны өргөл болон худалдааны хэлэлцээрийг байгуулав. Өмнө дурдсанчлан Мин улсын засгаас Хөх хотын Түмэд аймаг Датун хотын Шаху боомтод худалдаа хийхийг аль хэдийнээ зөвшөөрсөн байна. Ингэснээр Чин улс Хөх хотын Түмэд болон Харчин аймгийн нэрээр Мин улсын Датун, Шаху, Сюаньфүгийн Жанчхүү боомтын худалдааг бүрмөсөн хяналтдаа авсан. Үүнийг Мин улсын хүмүүс сайтар мэдэж байлаа.

Мин улсын дэд жанжин Ли Юйлан (李御兰) Чуньжэний арван дөрөвдүгээр онд хаанд өргөсөн бодрол бичиг.

*Би удаан хугацаанд Сюаньфү хотод амьдарч, Жанчхүү боомт дахь нүүдэлчдийн бараа, харилцан худалдааг ажиглав. Барааны ихэнх нь зүүн нутгаас ирж (~10 ханз дутуу) Би харийнхны хяналтын цэгийг хариуцагч Жэн Сянд очиж байцаан асуув. Сюаньфү хот Чуньжэний арван нэгдүгээр (1638) оноос баруун Харчин, Шаниань аймгийн хүмүүсийг дуудан авчирч (~ 14 ханз дутуу) тод өнгөтэй торгоны ашгийг хурааж мөн Манжийн ахлагчийн баруун хурууг таслав. Одоо боомт Харчин аймгийн мэдэлд орж, гурван удирдагчийг (Халхын гурван аймаг) хилд ирж худалдаа хийхийг зөвшөөрөхгүй болов. (~ 14 ханз дутуу) Зүрчидийн хяналтад Харчин аймаг орсон ба одоо харилцан худалдааг сэргээв. Бид одоо Зүрчид аймагтай худалдаа хийнэ гэсэн үг. (~ 10 ханз дутуу) гэхдээ бүх зүйлийг тушаалын дагуу (ханз дутуу), Сюаньфү боомтод зүүн зүгийн Зүрчидтэй худалдаа хийх ба Зүрчидүүд зүүн Ляодунг бүсэлсэн. Гэвч үүнээс эмээж худалдаа хийхийг зөвшөөрөх нь өөрийнхөө махыг огтолж барст өгсөнтэй адил юм. Тэд Сюаньфү боомтыг гурван жил манаж, цагдсан (ханз дутуу). Тэд худалдаа хийж, шагналын мөнгөнөөс завишиж чаддаг билээ. Бид Манж нарт*

<sup>44</sup> 参见《明代漠南蒙古历史研究》，第332-333页。

<sup>45</sup> 《清太宗实录》卷41，崇德三年三月甲戌。

<sup>46</sup> 《清太宗实录》卷42，崇德三年七月壬申。卷44，崇德三年十月己亥；卷46，崇德四年五月庚辰。

*Ляодуны бүслэлтийг чөлөөлөх саналыг яагаад тавьж болохгүй гэж? Тэгвэл тэд ч 3 жил Ляодуны хилийг зөрчихгүй, бид бас хилээ хамгаалж чадна. Тэгээд дараа нь худалдааны эрх олгох уу? Хэрэв чадахгүй бол (ханз дутуу) баруун нүүдэлчидтэй (夷虎 Харчин) нийлж, Зүрчидүүдэд хүндрэл үүсгэж болмуй. Бид тэдний мунхгийг үл хүлээн зөвшөөрч, зүрх сэтгэлд нь довтолгоо хийж, сэтгэлийг нь өдмүй. Жэнь Сян харцу хэлэхдээ: Энэ нөхцөлөөс Харчины байдлыг сайн мэдэж болно... ... арван дөрөвдүгээр он, 12-р сарын 27-нд хааны зарлигаар: Холбогдох яам мэдэж авсугай<sup>47</sup>.*

Илтгэлд дурдсанаар, Харчин аймаг Жанчхүү дахь харилцан худалдааг хянахаар болжээ. Жанчхүүгийн худалдааны боомтод ирэх бараа таваарын ихэнх нь Чин улсын бүтээгдэхүүн байв. Ингэснээр Халхын гурван аймаг аль хэдийн Сюаньфүд ирж, Мин улстай худалдаа хийх боломжгүй болсон байна.

Тэнгэр цэцэний есдүгээр он (1636), Чин улсын зүгээс халхчуудад Мин улстай худалдаа хийхгүй байхыг анхааруулж хориглосон. Үүний дараа Зүүн халхын Цэцэн хан Түшээт хан хоёр аймаг Чин улстай хэлэлцээр хийхээр элч илгээв. Дээд эрдэмт хааны гуравдугаар (1639) оноос Мин улстай шууд худалдаагаа зогсоож, харин Чин улстай худалдаа хийхээр болжээ. Дээд эрдэмт хааны гуравдугаар онд Халхын баруун гарын Засагт ханыг манжууд цэргийн хүчээр сүрдүүлж, дараа нь Чин улс энхийн гэрээг тулган шаардаж элч илгээв. Тус элчээр дамжуулан худалдаа хийх болов. Гэвч харилцан бичигт *одоо ч үргэлж чи бид харилцан эрх тэгш байдлыг хадгална* хэмээгээд дагаар орохоос татгалзсан<sup>48</sup>. Ийм учраас Хунтайж маш их хилэгнэж, түүний эсрэг чиглэсэн хол хязгаарын аян дайныг хийнэ гэж олон удаа заналхийлсэн байна. Дээд эрдэмт хааны тавдугаар онд Чин улсын Хунтайж дахин Засагт хан аймагт захидал бичиж илгээв. Захидалдаа, хэрэв ирж дагаар орох аваас Шаху боомтод худалдаа хийж болно. Эс тэгвээс цэрэг хөдөлгөж довтолно хэмээгээд байлдах газраа тогтсугай гэж мэдэгджээ<sup>49</sup>. Засагт хан Чин улсын заналхийлэлд хариу өгөхийн тулд Халх-Ойрадын холбоо, цэргийн эвсэл байгуулжээ<sup>50</sup>. Түүний зэрэгцээ Чин улс руу элч илгээж худалдааны харилцаагаа үргэлжлүүлж байв. Чин улс Мин улсын худалдаагаар өөрийн хэрэгцээ шаардлагыг хангахаас гадна<sup>51</sup> дотор газрын бараа бүтээгдэхүүнээр дагаар ороогүй Халх-Ойрад зэрэг монгол аймгуудтай арилжаа наймаа хийх болжээ. Мөн монголчуудтай худалдаа хийхийн тулд хүчээр харилцаа тогтоож, бүр цаашлаад албат дагаар орох нөхцөлийг бүрдүүлэв. Ингэснээр Мин улсын Халх-Ойрадтой холбоо тогтоож Манжийн хүчийг хязгаарлан барих стратегийн бодлого талаар болов. 1635-1637 оны эцэс хүртэл Халх аймаг, Мин улсын

<sup>47</sup> 兵科抄出原任功升副将李御兰奏本, 《原任功升副将臣李御兰奏为应旨恭陈难虏制奴奇谋乞敕督臣酌夺破愚攻 [约缺六字] 以解辽危事》, 中国科学院编:《明清史料》, 丁编, 第七本, 第 60 页。

<sup>48</sup> 《清太宗实录》卷 41, 崇德三年三月庚午。

<sup>49</sup> 《崇德帝斥责喀尔喀扎萨克图汗言行并约定会盟日期之敕谕》, 崇德五年三月初八日, 《清内秘书院蒙古文档案汇编》第 1 辑, 内蒙古人民出版社, 2003 年, 第 269-275 页

<sup>50</sup> 详见拙文 《1640 年喀尔喀—卫拉特会盟的召集人及地点》, 载 《民族研究》, 2008 年第 4

<sup>51</sup> 参见拙著 《明代漠南蒙古历史研究》, 第 331-336 页。

худалдаа гурван жил үргэлжилж, ойролцоогоор 50 мянган адуу арилжсан байна<sup>52</sup>. Чин улсын цэргийн хүчний хоригоос хойш халхчууд манжуудтай худалдаа хийх нөхцөл рүү шилжив. Чин улс говийн өмнөх монголчуудыг нэгтгэсний дараа Цахарын Лигдэн хааныг орлож, Мин улсын худалдаанд хяналт тавьж, өөрийн эдийн засгийн ашиг сонирхлоо баталгаажуулсан байна. Түүний зэрэгцээ Халхтай харилцан худалдаа хийх замаар хавчсанаар тэднийг эрхшээлдээ авах боломжийг бүрдүүлжээ. Мин улс Халхын худалдааг нэвтрүүлж, дайнд зарцуулах адуунууд олж авсан. Харин Халхыг ашиглаж Манжийн цэргийн баруун тийш тэлэлтийг саармагжуулах стратегийн оролдлого бүтэлгүйтсэн. Гэхдээ Чин улстай Түмэд болон Харчин зэрэг хоёр аймгийн нэрээр худалдаа хийхийг зөвшөөрсний дараа умардын цэргийн дарамтыг түр хугацаанд намжааж чаджээ. Энэ талбарын тоглолтын явцад эцэст нь Чин улс ялалтыг олжээ.

Хятад хэлнээс орчуулсан: Г. Жанлав  
*Өвөр Монголын Их Сургуулийн  
Угсаатан зүй, Нийгэм зүйн Дээд сургуулийн  
Түүхийн тэнхимийн магистрант*

### **Abstract**

After Ligdan Qayan of c̣ʼaqar died in 1634, the Qing controlled the Mongols of the Southern Gobi Desert, but despite Qing efforts to obstruct them, the Qalq-a of the Northern Gobi Desert renewed trade with Ming for a time. The Ming purchased horses from the Qalq-a for their military, and the Ming court even wanted to use the Qalq-a to thwart the western advance of Qing troops. The Qing court employed military threats and economic enticements to stop Qalq-a trade with the Ming and shift the trade to the Qing. Furthermore, in the name of the Tümed and Qarçʼ in tribes, the Qing court controlled the markets between the Mongols and the Ming, not only fulfilling its own economic needs, but also controlling the Qalq-a. Under military threat from the Qing, the Ming court tacitly allowed the Qing to trade indirectly to avoid an attack on its northern border

---

<sup>52</sup> 杨嗣昌：《庸材实员任使疏》，《杨文弱先生文集》卷 47，《四库禁毁书丛刊》集部第 69 册，第 358 页